



ТОГТВОРТОЙ УУЛ УУРХАЙН ТӨЛӨӨ



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

НУТГИЙН ИРГЭД БОЛОН ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ПРОТОКОЛ



ТУУТ (TSM) СТАНДАРТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ПРОТОКОЛ

Нутгийн иргэд болон орон нутгийн харилцааны гүйцэтгэлийн үнэлгээний арга зүй

Зорилго

Энэхүү үнэлгээний протоколын зорилго нь уурхайнуудад ТУУТ (TSM) стандартын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу Нутгийн иргэд болон орон нутгийн харилцааны гүйцэтгэлээ үнэлэхэд нь туслана. Үнэлгээний протокол нь ТУУТ (TSM) санаачилгын нэг хэсэг болох нутгийн иргэд болон орон нутгийн харилцааны чиглэлээрх ерөнхий хүлээлтийг тодорхойлсон. Энэхүү протокол нь ТУУТ стандартын Уул уурхай, ба орон нутгийн иргэдийн талаарх зарчмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг. Менежментийн тогтолцоонд хийгдэж буй аливаа үнэлгээний нэгэн адил системийн үзүүлэлтийн хэрэгжилтийн түвшин, менежментийн үйл явц, үйл ажиллагааны чанарыг үнэлэхэд мэргэжлийн дүгнэлт, шинжилгээ шаардлагатай байдаг. Тиймээс энэхүү протоколыг хэрэгжүүлэхэд аудит, системийн үнэлгээний чиглэлээр мэргэшсэн байх, нутгийн иргэд болон орон нутгийн харилцааны практик мэдлэг, туршлага шаардагдана. Энэхүү үнэлгээний протокол нь ТУУТ санаачилгын нэг хэсэг болох орон нутгийн иргэдийн идэвхтэй, оролцоог хэрхэн дэмжиж хэрэгжүүлж буйг үнэлэх үзүүлэлтүүдийг гарган өгдөг. Гэвч тухайн протокол нь нутгийн иргэд, орон нутгийн харилцааны үйл ажиллагааны үр дүнтэй байдлын баталгаа болохгүй.

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Энэхүү зорилтыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшил болон гүйцэтгэлийг үнэлэхийн тулд Орон нутгийн иргэд болон орон нутгийн харилцааны протокол нь таван үзүүлэлтэд хамаарах шалгууруудыг тогтоодог:

1. Сонирхогч бүлгүүдийг тодорхойлох (Communities of interest)
2. Сонирхогч бүлгүүдийн үр нөлөөтэй харилцаа ба хэлэлцүүлэг
3. Нутгийн иргэдтэй үр дүнтэй харилцах ба хэлэлцүүлэг
4. Орон нутагт үзүүлж буй нөлөө болон үр өгөөжийн менежмент
5. Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизм

Нутгийн иргэдийн оролцоо

Канад болон зарим улсад нутгийн иргэд нь хөрш зэргэлдээ амьдарч буй бусад иргэдээс өөр эрхийг эдэлдэг тул нутгийн иргэдтэй холбоотой үзүүлэлтийг энэхүү стандарт багтаах нь зөв зохистой юм. Энэхүү протоколын Үзүүлэлт 3 нь уул уурхайн компаниуд нь нутгийн иргэдтэй идэвхтэй харилцан, тэдний оролцоог хангаж, шийдвэр гаргах үйл явцад оролцуулдаг байхыг баталгаажуулахад зорьсон. Үүний хүрээнд уурхай нь бүтээн байгуулалт эхлүүлэхээс өмнө нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл, тэдний эрхийн талаар чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр өгсөн зөвшөөрлийг авах, үүнийг уурхайн үйл ажиллагааны туршид тогтмол хэрэгжүүлж байх явдал мөн багтана. Тус үзүүлэлт нь мөн компанийн олгож буй боломжууд нь нутгийн иргэдэд тэгш хүртээмжтэй байлгах талаар хүчин чармайлт гаргаж буй эсэхийг үнэлж баталгаажуулдаг. Түүнчлэн энэ үзүүлэлт нь компанийн удирдлага, томилогдсон ажилтнууд нь нутгийн иргэдийн түүхийн талаар мэдлэгтэй, соёлын ялгаатай байдлыг ойлгох мэдрэмж, ур чадвар, зөрчил шийдвэрлэх, хүний эрх болон арьс өнгөөр ялгаварлахын эсрэг сэдвүүдээр мэдлэг, ур чадвар олгох сургалтуудад хамрагдсан эсэхийг мөн шалган баталгаажуулна. Үзүүлэлт 3 нь энэхүү протоколын 2 дугаар үзүүлэлт дээр тайлбарласан оролцоо, хэлэлцүүлгийн тогтолцоо дээр үндэслэдэг. Канадаас бусад улсад энэхүү протоколыг ашиглаж буй компаниудын хувьд тэдний үйл ажиллагаа нь уламжлалт газар эзэмшил, эрх, нутгийн иргэдийн эзэмшлийн нөөц баялагт сөрөг нөлөө үзүүлж буй бол 3 дугаар үзүүлэлтийг ашиглах нь зүйтэй.

3 дугаар үзүүлэлтийн хэрэгжилтийг хангахад НҮБ-ын Нутгийн иргэдийн эрхийн тухай тунхаглалд (UNDRIP) заасан зарчим, хэм хэмжээ болон стандартууд, эрх зүйн/ зохицуулалтын шаардлагууд үндсэн чиглэл болно. Нутгийн иргэдэд шууд сөрөг нөлөөлөл үзүүлж болохуйц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс өмнө, ялангуяа тэдний уламжлалт газар нутагт хэрэгжих төслүүд дээр нутгийн иргэдтэй зөвлөлдөж байх төрийн үндсэн үүрэг болохыг хүлээн зөвшөөрч компаниуд ч зөвлөлдөх арга хэмжээтэй холбоотой төрийн үүргийг орлон гүйцэтгэх оролдлого гаргах шаардлагагүй, тэгэх ч үүрэггүй байна. Энэхүү Үзүүлэлт нь уурхайн зүгээс нутгийн иргэдтэй бодит харилцаа, хүндэтгэлтэй оролцоо, шийдвэр гаргах үйл явцыг бий болгон, хадгалж, сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн дэмжлэгийг авах, үүнийг хадгалах зорилтдоо хүрч буй эсэхийг үнэлэхэд төвлөрдөг.

Канад улсын хувьд ашигт малтмалын олборлолтой холбоотойгоор шийдвэр гаргахад нутгийн иргэд, төр болон салбарын оролцоо нь чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөх зарчмын талаарх хамтын ойлголт дээр үндэслэж, Канад улсын хууль, Үндсэн хуулийн хүрээнд хийгддэг. Үүний нэгэн адил чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөх зарчмыг Канад улсаас бусад улсад ч тухайн улс, орон нутгийн хууль тогтоомж, үндсэн хуулийн хүрээллийг хүндэтгэхтэй мөн холбоотойгоор баримтална. Канадын Уул уурхайн ассоциаци нь чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөх зарчмыг өргөн хүрээнд дэмжлэг авах, үүнийг хадгалах зорилгод хөтлөх байнгын оролцоог хангах үйл явц хэмээн үздэг ч бүх талууд санал нэгтэй байх нь боломжгүй байж болох юм.

ҮЗҮҮЛЭЛТ 1: СОНИРХОГЧ БҮЛГҮҮДИЙГ ТОДОРХОЙЛОХ

Зорилго

Компанийн үйл ажиллагаа, арга хэмжээний сөрөг нөлөөлөлд өртөж буй эсвэл өртөж буй хэмээн үзэж буй эсвэл компани болон/эсвэл үүний үйл ажиллагаанд бодит сонирхол бүхий сонирхогч бүлгийг (үүнд нутгийн иргэд, байгууллагууд багтана) тодорхойлох үйл явц тогтож, хэвшсэн эсэхийг баталгаажуулах. Уурхайн үйл ажиллагааны бүхий л хугацааны турш сонирхогч бүлгүүдийг тодорхой давтамжтайгаар эргэн хянадаг үйл явц хэвшин тогтсон байх нь чухал.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	- Зарим сонирхогч бүлгийг олж тодорхойлсон байх. - Сонирхогч бүлгийг тодорхойлох үйл явц бүрдсэн байх.
А	- Уурхайн түвшинд талуудын олон төрлийн ашиг сонирхол, санаа зовж буй асуудлыг тодорхойлон гаргахад туслах сонирхогч бүлгийг тодорхойлох, баримтжуулсан үйл явц бүрдсэн байх. - Энэхүү үйл явцад дараах зүйлс багтсан байх: - Сонирхогч бүлгүүдэд зориулсан өөрсдийгөө тодорхойлох механизмтай байх - Тодорхойлон гаргасан Сонирхогч бүлгүүдийн талаарх мэдээлэлтэй, энэ нь тогтмол шинэчлэгдэж байх үйл явц тогтсон байх - Сонирхогч бүлгийн зүгээс хүсэлт гаргасан тохиолдолд нууцлалыг хангах зүйл заалттай байх - Уурхайн үйл ажиллагаа явуулах бүхий л хугацааны туршид Сонирхогч бүлгийг тодорхой давтамжтайгаар дахин эргэн авч үздэг байх. - Уурхай нь өөрийн тодорхойлсон Сонирхогч бүлгүүдийн жагсаалтыг гаргаж, байнга эргэн хянаж, шинэчилдэг байх.

AA	- Баримтжуулсан үйл явц нь доорх бүлгийг тодорхойлох талаар багтаасан байх: - Орон нутаг дахь хязгаарлагдмал төлөөлөл бүхий Сонирхогч бүлгүүд - Уурхайн үйл ажиллагаанаас ашиг сонирхолд нь шууд бус нөлөөлөлд орох эсвэл тодорхой асуудалд суурилсан сонирхогч бүлгүүд (жишээ нь үндэсний, орон нутгийн, олон улсын ТББ) - Уурхайн зүгээс Сонирхогч бүлгийг хэрхэн тодорхойлж буй дээр саналаа өгөхийг Сонирхогч бүлгүүдэд хандан урьдаг байх.
AAA	- Сонирхогч бүлгийг тодорхойлох системийг Сонирхогч талуудтай тодорхой хугацааны давтамжтай хянаж, байнга сайжруулж байх боломжийг бүрдүүлсэн байх. - Сонирхогч бүлгийг тодорхойлох үйл явцыг шинэчлэхдээ сонирхогч бүлгүүдийн өгсөн саналыг харгалзан үздэг байх. - Сонирхогч бүлгийн саналыг харгалзан авч үзээгүй бол ямар шалтгааны улмаас тухайн саналыг тусгаагүй болохоо Сонирхогч бүлгүүдэд эргэн тайлбарладаг байх.

Түгээмэл асуултууд: Сонирхогч бүлгүүдийг (COI) тодорхойлох

#	Түгээмэл асуултууд
1	Нутгийн иргэд гэж хэн бэ?
2	Сонирхогч бүлэг (COI) гэж хэн бэ?
4	Уурхайн түвшний үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн түвшний баримт бичгүүдийг ашиглах боломжтой юу?
5	Уурхай нь шууд нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэдийг хэрхэн тодорхойлж болох вэ?
6	Бүс нутгийн түвшний оролцоог хангах чиглэлээр хийж буй ажлыг үнэлгээнд хэрхэн тусгаж болох вэ?
11	Уурхай нь тодорхойлон гаргасан Сонирхогч бүлгээс хязгаарлагдмал төлөөлөлтэй гэж тогтоосон бүлгийг харгалзан үзэж буйгаа хэрхэн илтгэн харуулах вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 2: СОНИРХОГЧ БҮЛГҮҮДИЙН ҮР НӨЛӨӨТЭЙ ХАРИЛЦАА БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Зорилго

Сонирхогч бүлгүүдтэй (үүнд нутгийн иргэд болон байгууллагууд багтана) бодит, бүтээлч харилцааг бий болгосноор хамтын ойлголтыг бүрдүүлж, үр дүнтэй харилцааг бий болгож, хамтын үнэт зүйлсийг бүтээж, хамтын өгөөж бүрдүүлэх үйл явц бүрдсэн эсэхийг баталгаажуулах.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	1. Уурхай нь шаардлагатай/ зохистой үед Сонирхогч бүлгүүдтэй харилцах, хэлэлцүүлгийн үйл явцад оролцох боломжоор ханган туслалцаа үзүүлдэг байх. 2. Сонирхогч бүлгийн харилцаа болон хэлэлцүүлгийн талаар дотоод тайлагнал зарим түвшинд хийгддэг байх. 3. Сонирхогч бүлгүүдтэй харилцах үйл явц зарим талаар явагдаж, хааяа хэлэлцүүлэг хийдэг байх. 4. Сонирхогч бүлгүүдтэй харилцах албан ёсны үйл явцыг хөгжүүлж байх
А	1. Сонирхогч бүлгүүдтэй харилцах, хэлэлцүүлэг хийх үйл явцыг тэдний оролцоотойгоор боловсруулж, баримтжуулсан үйл явц тогтсон байх. 2. Сонирхогч бүлгүүдтэй хэрхэн харилцаж буй талаарх үр дүнг ахлах удирдлага болон нөлөөнд өртөж буй Сонирхогч талуудын бүлгүүдтэй хамтран байнга, урьдчилан тогтоосон давтамжтайгаар эргэн хянах үйл явц бүрдэн тогтсон байх. 3. Мэдээлэл харилцаа нь Сонирхогч талуудын бүлгийн хэл дээр тодорхой, ойлгомжтой бичигдсэн байх. 4. Холбогдох материалуудыг Сонирхогч талуудын бүлэгт хянуулахаар хүртээмжтэй, цаг тухайд нь гарган өгдөг байх. 5. Сонирхогч бүлгийн сонирхож, санаа зовниж буй асуудлын талаар үр дүнтэйгээр оролцох боломжийг нь хангахын тулд тэдний чадавхыг бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлох үйл явц бүрдэн тогтсон байх. 6. Томилогдсон ажилтнуудад сонирхогч бүлгүүдтэй хэрхэн харилцах, хэлэлцүүлэг хийх, тэдний соёлын онцлогын талаарх сургалт зохион байгуулсан байх. 7. Сонирхогч бүлгүүдтэй хэрхэн харилцдаг талаар олон нийтэд мэдээлдэг¹ байх, үүнд тайлант хугацаанд сонирхогч талуудтай харилцах талаар хийгдсэн ажлын төрөл, сэдэв зэргийг тусгадаг байх.

¹ Сонирхогч талуудын бүлгийг тодорхойлсон байдал/ тэдний асуудлууд нь нууцлал бүхий хэмээн тооцогдох бол компанийн зүгээс Сонирхогч талын бүлэгтэй тогтоосон харилцаа, тэдний илэрхийлж буй асуудал, компанийн хариу үйлдэл зэргийг олон нийтэд ил тод тайлагнахыг шаардахгүй.

АА	1. Харилцааны үйл явцыг Сонирхогч бүлэгтэй хамтран эргэн хянаж, бүлгүүд нь асуудал, боломжуудыг тодорхойлоход үр дүнтэй оролцон, тэдэнд нөлөөлөхүйц шийдвэр гаргахад оролцох боломжийг ханган баталгаажуулдаг байх 2. Уурхай нь Сонирхогч бүлгийн бодит оролцоог хангаж, тогтмол харилцдаг түүхтэй, туршлагатай байх. 3. Үйл явц нь хязгаарлагдмал төлөөлөлтэй хэмээн тогтоосон Сонирхогч бүлгийг харгалзан үзэж оруулсан байх. 4. Яриа хэлэлцүүлэгт үр дүнтэй оролцох боломжийг хангахын тулд Сонирхогч бүлгүүдийн чадавхыг бүрдүүлэх, бэхжүүлэх үйл явц тогтсон байх. 5. Сонирхогч бүлэг нь байнгын сайжруулалт хийх зорилгоор харилцааны үйл явцын хяналтад оролцон хувь нэмэр оруулдаг байх. 6. Сонирхогч бүлгүүдийн харилцаа болон үр дүнгийн талаар сонирхогч бүлгийн санал, бодлыг идэвхтэй эрэлхийлж, олон нийтэд тайлагнадаг байх. 7. Харилцааны талаарх олон нийтэд зориулан гаргасан тайлагналд Сонирхогч талуудын бүлэг саналаа илэрхийлэх боломж нээлттэй байх.
ААА	1. Харилцааны үйл явцыг Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран боловсруулдаг, боломжтой бол зөрчил шийдэх механизмтай байх. 2. Сонирхогч талуудын бүлэг нь тэдэнд шууд сөрөг нөлөө үзүүлж буй болон/эсвэл ашиг сонирхол бүхий харилцан тохирсон асуудлаар хамтарсан шийдвэр гаргахад оролцдог байх. 3. Харилцааны системийн үр дүнтэй эсэхийг Сонирхогч бүлгүүдтэй хамтран хийж, тодорхойлон гаргасан сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байх. 4. Харилцааны талаарх олон нийтэд зориулсан гаргасан тайлагналд харилцааны үр дүнтэй байдлын талаарх мэдээллийг багтаадаг байх.

Түгээмэл асуултууд: Сонирхогч бүлгийн үр дүнтэй харилцаа ба хэлэлцүүлэг

#	Түгээмэл асуултууд
1	Нутгийн иргэд гэж хэн бэ?
2	Сонирхогч талуудын бүлэг (COI) гэж юу вэ?
3	Сонирхогч талуудын бүлгүүдийг оролцуулах, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангахын тулд тэдэнд ямар төрлийн тусламж дэмжлэг үзүүлж болох вэ?
4	Уурхайн түвшний үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн түвшний баримт бичгүүдийг ашиглах боломжтой юу?
6	Бүс нутгийн түвшний оролцоог ханган ажиллаж буй ажлыг үнэлгээнд хэрхэн тусгаж болох вэ?
7	Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллаж буйгаа уурхай нь хэрхэн илтгэн харуулж болох вэ?
8	АА түвшний үнэлгээний хүрээнд Үзүүлэлт 2 ын дагуу Сонирхогч талуудын бүлэг нь харилцааны үйл явцыг тодорхой хугацаанд хянахад өөрийн хувь нэмрийг хэрхэн оруулж болох вэ?
9	Уурхай нь сонирхогч бүлгүүдтэй хэрхэн харилцдаг талаар олон нийтэд тайлагнах ямар ямар арга замууд байдаг вэ?
10	Нутгийн иргэд эсвэл бусад Сонирхогч талуудын бүлэг нь уурхайтай хамтран ажиллах, оролцох сонирхолгүй эсвэл хүсэл эрмэлзэлгүй байгаа нөхцөлд ямар хүлээлт тавигдах вэ?
11	Уурхай нь тодорхойлон гаргасан Сонирхогч бүлгээс хязгаарлагдмал төлөөлөлтэй гэж тогтоосон бүлгийг харгалзан үзэж буйгаа хэрхэн илтгэн харуулах вэ?
22	“Тодорхой, ойлгомжтой” гэж юу гэсэн утгатай вэ?
23	“Чадавх бүрдүүлэх” гэж ямар утгатай вэ?
24	“Харилцаа” болон “хэлэлцүүлэг” гэж юу вэ?
25	“Ахлах удирдлагыг” хэрхэн тодорхойлж болох вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 3: НУТГИЙН ИРГЭДТЭЙ ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦАХ БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Зорилго

Энэхүү Үзүүлэлт нь компани, уурхай нь орон нутгийн иргэдтэй бодит бүтээлч харилцааг идэвхтэйгээр үүсгэж буй, оролцоог ханган хэрэгжүүлж буй, шийдвэр гаргах үйл явцад оролцуулж буйг баталгаажуулах зорилготой. Үүнд компани нь бүтээн байгуулалт эхлүүлэхээс өмнө нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл, тэдний эрхийн талаар чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр өгсөн зөвшөөрлийг авах, үүнийг уурхайн үйл ажиллагааны туршид давтан хэрэгжүүлж байх зорилтыг баталгаажуулах мөн багтана. Тус үзүүлэлт нь мөн компани өөрийн олгож буй боломжуудыг нутгийн иргэдэд тэгш хүртээмжтэй байлгах талара хүчин чармайлт гаргаж буйг мөн баталгаажуулдаг. Түүнчлэн үзүүлэлт нь компанийн удирдлага, томилогдсон ажилтнууд нь нутгийн иргэдийн түүхийн талаар мэдлэгтэй, соёл хоорондын чадамжтай байдал, зөрчил шийдвэрлэх, хүний эрх болон арьс өнгөөр ялгаварлахын эсрэг зэрэг сэдвээр холбогдох сургалтуудад хамрагдсан эсэхийг шалган баталгаажуулна.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	- Нутгийн иргэдтэй харилцан, оролцоог нь хангахаа илтгэн харуулж буй үүрэг амлалт, эрмэлзэл нь тодорхой байх. - Шууд нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй харилцах зарим үйл явц бүрдэж, яриа хэлэлцүүлэг заримдаа хийгддэг байх. - Нутгийн иргэдэд ямар асуудал чухал болохыг тодорхойлох зорилгоор тэдэнтэй харилцдаг, хэлэлцүүлэг өрнүүлэхэд татан оролцуулах үйл явцыг боловсруулж (эсвэл хэрэгжүүлж) байх. Ингэхдээ орон нутгийн хэл, заншил, соёл, хууль тогтоомжийг судлан ашигладаг байх. - Томилогдсон ажилтнуудын чадамжийг хангах болон/эсвэл дараах чиглэлээр сургалт хийх үйл явцыг боловсруулж (эсвэл хэрэгжүүлж) байх: - Зөвлөлдөх арга хэмжээний шаардлагууд - Сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн түүх, уламжлал болон эрх - Соёлын ялгаатай байдлын талаарх мэдлэг, мэдрэмжтэй харилцаа

А	1. Ахлах удирдлагын зүгээс нутгийн иргэдийн харилцаа, оролцооны чиглэлээр ТУУТ (TSM) стандартын Уул уурхай, нутгийн иргэдийн талаар баримтлах бодлогын дагуу өөрийн үүрэг амлалт/ хичээл зүтгэлийг илтгэн харуулсан байх, үүнд дараах үүрэг амлалт багтсан байх: a. Бодит байнгын харилцаа, оролцоо b. Хүндэтгэлтэй харилцах c. Шинэ төсөл эхлүүлэх эсвэл өргөтгөл хийхээс өмнө сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн чөлөөт, урьдчилсан, мэдлэгтэйгээр өгсөн зөвшөөрлийг авахыг зорих d. Уурхайн үйл ажиллагаатай холбогдон гарч буй боломжууд нь нутгийн иргэдэд тэгш, хүртээмжтэй байх e. Сөрөг нөлөөнд өртсөн нутгийн иргэдэд урт хугацааны тогтвортой үр өгөөж хүртээхийг зорих, хичээх 2. Сөрөг нөлөөнд шууд өртөж буй нутгийн иргэдтэй дараах чиглэлээр харилцах, оролцоог нь хангах үйл явц тогтсон байх: a. Нутгийн иргэдэд чухал ач холбогдол бүхий зүйлсийг, үүнд соёлын хувьд ач холбогдол бүхий газар нутаг², тэдний эрх болон ашиг сонирхолд хэрхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болох болон эдгээр сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулж болох талаар ойлголт авахаар эрэлхийлэх b. Орон нутгийн хэл, уламжлал, заншил болон сөрөг нөлөөнд өртөж буй иргэдийн бий болгосон нутгийн иргэдийн засаглал, оролцооны үйл явцын талаар мэдээлэлтэй байх c. Иргэдийн өргөн хүрээний дэмжлэг авч, үүнийг удаан хугацаагаар хадгалан үлдээх чиглэлээр бодит, хүндэтгэлтэй харилцаагаар төлөвлөсөн байх d. Орон нутгийн нутгийн иргэд, байгууллагуудаас тухайн иргэдийн соёл, оюун санаа болон/ эсвэл нутгийн мэдлэгийг эрэлхийлж, боломжтой үед өөрийн шийдвэр, арга ажиллагаанд үр дүнтэйгээр тусгаж байх
---	--

² ТУУТ (TSM) стандартыг баримтлах замаар Коппер Марк (Copper Mark) байгууллагын шаардлагуудыг хангахаар ажиллаж буй уурхайн хувьд соёлын өвийг хамгаалахтай холбоотой нэмэлт шаардлагыг тус стандартын Хариуцлагатай худалдан авалтын нэмэлт баримт, 24 дүгээр зүйл дээр (Responsible Sourcing Alignment Supplement) заасан ба үүний хүрээнд уурхай нь соёлын өв бүхий газар нутгийг олж тодорхойлох, оролцогч талуудтай хийх зөвлөлдөх арга хэмжээнд суурилсан, соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, багасгах, нөхөн төлөх үйл явцыг бий болгосон байхыг шаарддаг.

А	3. Уурхай нь сөрөг нөлөөлөлд шууд өртсөн нутгийн иргэдтэй хамтран ажиллаж орон нутгийн боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, бизнес, орлого олох боломж, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүд болон өөр бусад чиглэлээр хамтран ажиллах боломжуудыг тодорхойлох. 4. Уурхай нь өөрийн сөрөг нөлөө үзүүлж буй соёлын хувьд ач холбогдол бүхий газар нутгийн талаар (байгаа бол) шууд сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй хамтын хэлцэлд хүрэх зорилтыг дэвшүүлсэн байх. 5. Томилогдсон ажилтнуудын чадамжийг хангах болон/эсвэл дараах чиглэлээр сургалт хийх үйл явцыг боловсруулж (эсвэл хэрэгжүүлж) байх: a. Зөвлөлдөх арга хэмжээний шаардлагууд b. Сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн түүх, уламжлал болон эрх c. Соёлын ялгаатай байдлын талаарх мэдлэг, мэдрэмжтэй харилцаа
АА	1. Нутгийн иргэдийн зүгээс бүрдүүлсэн харилцаа, оролцооны протоколыг уурхай батлан хэрэгжүүлж буйгаас бусад тохиолдолд харилцаа, оролцооны үйл явцыг шууд сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй хамтран боловсруулсан (эсвэл боловсруулж буй) байх. Үүнд дараах үйл явцыг бий болгохыг багтаана: a. Уурхай болон шууд нөлөөнд өртөж буй иргэд хэрхэн харилцан зөвшилцөлд хүрэх талаар тодорхойлох b. Хэрэв байгаа бол шийдвэр гаргах уламжлалт үйл явцыг хэрхэн уялдуулан хангахыг тодорхойлох c. Зөрчлийг үр дүнтэйгээр шийдэх 2. Шууд нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэдтэй хамтран тодорхойлсон боломжуудын чиглэлээрх харилцан зөвшилцсөн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл явц хэрэгжиж байх. 3. Нутгийн иргэдийн талаарх боловсрол, мэдлэг болон/эсвэл түүх, уламжлал, эрх, соёлын ялгаатай байдлын талаарх сургалтууд нь доорх нөхцлийг хангасан байх: a. Бүх ажилтнуудад зориулагдсан, нээлттэй байх b. Зөвхөн удирдлага болон томилогдсон ажилтнуудаас гадна бүх ажилтнуудыг хамруулах зорилттой байх 4. Боловсрол, мэдлэг, мэдээллийн агуулга нь дараах шаардлагад нийцсэн байх: a. Нутгийн иргэдтэй хамтран боловсруулсан болон/эсвэл хамтран хийсэн байх b. Нутгийн иргэдийн оролцоотойгоор байнга хянаж, шинэчилдэг байх

AAA	1. АА түвшин дээр тодорхойлсон харилцаа, оролцооны үйл явцыг хэрэгжүүлж, шууд сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй зөвшилцөлд хүрсэн эсвэл харилцан зөвшөөрсөн үүрэг амлалт авсан байх. 2. Уурхай нь нутгийн иргэдтэй хийсэн гэрээ хэлцэл, зөвшилцлийг даган мөрдөж, хэрэгжүүлж, хэрэгжилтийг хянаж буйгаа илтгэн харуулах. 3. Уурхай нь АА түвшинд тодорхойлсон хамтын зорилтууд дээр нутгийн иргэдтэй хамтран ажилладаг, үр дүн эсвэл өгөөж бий болгоход гарч буй ахиц дэвшлийн талаарх нотолгоог гарган өгөх. 4. Зорилтуудаа хангаж буйг хэмжих хамтын үнэлгээний үйл явц бүрдэж, үүнд дараах үйл явц багтсан байх: a. Гүйцэтгэлийг нутгийн иргэдтэй хамтран баталгаажуулах b. Зорилтууд нь биелэгдээгүй тохиолдолд нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх 5. Ажилтнуудынхаа нутгийн иргэдийн түүх, уламжлал болон эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, соёлын ялгаатай байдлын талаарх мэдлэг, мэдрэмжтэй харилцааг бий болгох чиглэлээр доорхоос хамгийн багадаа гурван нөхцлийг хангасан байх: a. Уурхайн ажилтнуудад нутгийн иргэдийн түүх, уламжлал, эрх болон соёлын ялгаатай байдлын талаарх мэдлэг олгох, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах b. Орон нутагт хийгдэж буй соёлын үйл ажиллагааг уурхайн зүгээс дэмжих c. Уурхай нь өөрийн ажилтнуудыг орон нутгийн арга хэмжээнд оролцоход хөхиүлэн дэмжих d. Уурхай нь орон нутаг, бүс нутаг болон/эсвэл улсын хэмжээний нөлөөллийн ажлуудад хувь нэмэр оруулах эсвэл оролцох e. Мэдлэг, мэдээлэл олгох сургалтууд үр дүнтэй байгаа эсэхийг тогтмол үнэлэх f. Мэдлэг, мэдээлэл олгох сургалтуудыг зөвхөн уурхай дээр биш илүү өргөн хүрээнд өргөжүүлэх e. Уламжлалт болон соёлын үйл ажиллагааний протоколыг бизнесийн практиктай уялдуулан нэгтгэх
-----	--

Түгээмэл асуултууд: Нутгийн иргэдтэй үр дүнтэй харилцах ба хэлэлцүүлэг

#	Түгээмэл асуултууд
1	Нутгийн иргэд гэж хэн бэ?
2	Сонирхогч талуудын бүлэг (COI) гэж юу вэ?
3	Сонирхогч талуудын бүлгүүдийн оролцоог хангах, харилцах, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангахын тулд тэдэнд ямар төрлийн тусламж дэмжлэг үзүүлж болох вэ?
4	Уурхайн түвшний үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн түвшний баримт бичгүүдийг ашиглах боломжтой юу?
6	Бүс нутгийн түвшний оролцоог ханган ажиллаж буй ажлыг үнэлгээнд хэрхэн тусгаж болох вэ?
7	Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллаж буйгаа уурхай нь хэрхэн илтгэн харуулж болох вэ?
10	Нутгийн иргэд эсвэл бусад Сонирхогч талуудын бүлэг нь уурхайтай хамтран ажиллах, оролцох сонирхолгүй эсвэл хүсэл эрмэлзэлгүй буй нөхцөлд ямар хүлээлт тавигдах вэ?
12	Уурхай нь албан ёсны гэрээ (жишээ нь Нөлөөлөл, оүр өгөөжийн гэрээ) байхгүй бол Үзүүлэлт 3 AAA түвшнийг хангаж буйгаа хэрхэн илтгэн харуулж болох вэ?
13	Үзүүлэлт 3 (Түвшин А- AAA) дээрх боловсрол, мэдлэгтэй хамаарах шалгуурыг хангахын тулд уурхай нь бүх ажилтнууддаа ижил түвшний сургалт хийх шаардлагатай юу?
14	Нутгийн иргэдийн харилцаа, оролцоо, зохицуулалтын хүрээнд тавигдах мэдлэг, ур чадвартай гэдгээ хэрхэн илтгэн харуулах боломжтой вэ?
15	Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллах замаар тодорхойлж болох зорилтуудын ямар ямар жишээ байж болох вэ?
16	Нутгийн иргэдийн амьдардаг газар нутгаас хол байршилтай уурхай нь Үзүүлэлт 3 дээрх шалгууруудыг хангаж буйгаа хэрхэн нотлох вэ?
27	Орон нутгийн болон нутгийн иргэдийн мэдлэг гэж юуг хэлэх вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 4: ОРОН НУТАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ БОЛОН ҮР ӨГӨӨЖИЙН МЕНЕЖМЕНТ

Зорилго

Орон нутагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг (үүнд мөн хүний эрхийн нөлөөлөл багтана) тодорхойлж, сэргийлж, бууруулдаг үйл явц бүрдэн тогтож, уурхайн зүгээс үзүүлэх нийгмийн үр өгөөжийг хөхиүлэн дэмжиж, оновчтой хэрэгжүүлж буйг баталгаажуулах. Түүнчлэн энэхүү үзүүлэлт нь уурхайн зүгээс үүсэж болох сөрөг нөлөөлөлд өртөж болох сонирхогч талуудын бүлгийг тодорхойлж, сөрөг нөлөөллийн талаар мэдээлж харилцдаг эсэхийг үнэлнэ. Үүсэж болох сөрөг нөлөөлөлд хаягдлын менежмент, орон нутгийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зэрэг асуудлууд орно.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	1. Уурхайн үйл ажиллагаанаас улбаатайгаар Сонирхогч талуудын бүлэгт шууд нөлөө үзүүлэх болон бодитоор үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох болон бууруулах, орон нутагт өгөх үр өгөөжийг оновчтой болгохын тулд ахлах удирдлагын зүгээс үүрэг амлалт авсан байх. 2. Энэхүү үүрэг амлалтыг хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой хариуцуулсан байх. 3. Уурхай нь үйл ажиллагаанаас нь болж сонирхогч бүлгүүдэд сөргөөр нөлөөлж буй болон эсвэл боломжит нөлөөг тодорхойлсон байх. 4. Уурхай нь тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр зарим хүчин чармайлт гаргаж буйгаа илтгэн харуулах. 5. Орон нутагт хувь нэмэр оруулах зарим шийдвэрүүд гарсан байх. 6. Уурхай нь сөрөг нөлөөлөл, нөлөөллийн чиг хандлага болон нөлөөллийн менежментийн талаар хааяадаа мониторинг хийдэг байх.

А	1. Уурхайн үйл ажиллагаанаас улбаатайгаар Сонирхогч талуудын бүлэгт шууд болон бодитоор үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, эрэмбэлэх, сэргийлэх болон бууруулахад Сонирхогч талуудын бүлэгтэй харилцах, оролцоог хангах үйл явц тогтсон байх. 2. Боломжит болон бодит нөлөөллийг эрэмбэлэх үйл явц нь дараах нөлөөллийг харгалздаг байх: a. Уурхай үйл ажиллагаа явуулж буйн улмаас гарч болох нийгмийн сөрөг нөлөөлөл b. Нутгийн иргэдэд шууд нөлөөлөх байгаль орчны сөрөг нөлөөлөл, үүнд хаягдлын менежменттэй холбоотой нөлөөлөл (хамаатай бол) c. Орон нутгийн аюулгүй байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл 3. Харилцах, оролцоог хангах үйл явц нь хязгаарлагдмал төлөөлөл бүхий болон тодорхойлон гаргасан боломжит болон бодит сөрөг нөлөөлөлд хамгийн ихээр өртөж буй Сонирхогч бүлгүүдийн төлөөллийг оролцуулах арга хэмжээг багтаасан байх. 4. Нөлөөллийг эрэмбэлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамаарах Сонирхогч талуудтай хамтран хийсэн байх. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлж байх. a. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хамаарах зорилтууд, хүрэх түвшнийг тодорхойлсон байх, эдгээрийг хянаж, эргэн шалгаж, сөрөг нөлөөнд өртөж буй Сонирхогч талуудын бүлгийн хамтаар уян хатан удирдаж байх b. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь хэрхэн Сонирхогч бүлгийн хүртэх өгөөжийг оновчтой болгож болохыг харгалзан тусгасан байх. 5. Сонирхогч бүлгийн хүртэх үр өгөөжийг оновчтой болгох боломжийг тодорхойлох, эрэмбэлэхэд хамаарах бүлгийг татан оролцуулах үйл явц тогтсон байх. Үүнд орон нутгийн худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт болон бусад санаачлагууд багтсан байх.
---	---

А	6. Орон нутгийн үр өгөөжийг оновчтой болгохоор эрэмбэлсэн боломжуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамаарах Сонирхогч бүлгүүдийн оролцоотойгоор боловсруулан гаргаж, хэрэгжүүлж байх. а. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хамаарах зорилтууд болон хүрэх түвшнийг тогтоож, эдгээрийг эргэн хянаж, үнэлж, сөрөг нөлөөнд өртөж буй бүлэгтэй хамтран уян хатан удирдаж байх. 7. Уурхайн зүгээс орон нутгийн хөгжлийн санаачилгуудад оруулж буй хувь нэмэр дээр хамаарах Сонирхогч талуудын бүлэгтэй харилцдаг, оролцоог хангах үйл явц тогтсон байх. 8. Орон нутгийн хөгжлийн санаачилгуудад оруулж буй хувь нэмрийн талаар олон нийтэд мэдээлдэг байх. 9. Эрэмбэлсэн тэргүүлэх ач холбогдол бүхий сөрөг нөлөөллийн талаарх суурь өгөгдөл цуглуулдаг байх. 10. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт хийх хэмжих үзүүлэлт гаргасан байх. 11. Сөрөг нөлөөнд өртөж буй сонирхогч талуудын бүлэгтэй хамтран байнгын, урьдчилан тогтоосон давтамж, үндэслэлтэйгээр төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг хянадаг байх.
АА	1. Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран эрэмбэлэн гаргасан сөрөг нөлөөллөөс сэргийлэх эсвэл бууруулахын тулд шийдвэр гаргадаг үйл явц тогтсон байх. 2. Сонирхогч бүлгийн хүртэх үр өгөөжийг оновчтой болгох боломжуудыг тодорхойлох, эрэмбэлэх үйл явц нь дараах боломжуудыг харгалзах: а. Орон нутагт аль болох олон хүнд үр өгөөжтэй байх. б. Уурхайн үйл ажиллагаа дууссанаас хойш бие даан хөгжих боломжтой байх. 3. Хамаарах Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран шийдвэр гаргах, талуудын хүртэх үр өгөөжийг оновчтой болгох үйл явц тогтсон байх. 4. Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран уурхайн зүгээс орон нутгийн хөгжлийн чиглэлээр оруулах хувь нэмрийг гаргадаг байх. 5. Уурхай нь боломжтой бол Сонирхогч талын бүлэгтэй хамтран өөрийн тодорхойлсон, эрэмбэлсэн сөрөг нөлөөллийн чиг хандлагыг байнга хэмжиж, дүн шинжилгээ хийдэг байх. Уурхай нь мөн орон нутгийн үр өгөөжийг оновчтой болгох боломжуудыг байнга хэмжиж, дүн шинжилгээ хийж, гарч буй хийдлийг хэрхэн шийдэх талаар Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт арга хэмжээ авах.

AAA	1. Уурхай нь Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран эдгээр бүлгүүд уурхайн үйл ажиллагаа дууссаны дараа гарах сөрөг нөлөөллийг бууруулах, үр өгөөжийг оновчтой болгон ажиллах чадвартай болоход нь дэмжин ажиллана. Үүнд: a. Сөрөг нөлөөллийг бууруулах болон үр өгөөжийг оновчтой болгоход шаардлагатай боломжит түншлэл болон төрийн байгууллагын үүрэг ролийг тодорхойлох b. Урт хугацааны сөрөг нөлөөллийг бууруулах болон/эсвэл уурхайн үйл ажиллагаа зогссоны дараа орон нутагт очих үр өгөөжийг оновчтой болгох боломжуудыг тодорхойлон гаргасан бол эдгээрийг урт хугацааны хөрөнгө оруулалтын шийдвэр болон/эсвэл хаалтын төлөвлөгөөнд уялдуулан нэгтгэх замаар урт хугацааны тогтвортой байдлыг хангах. 2. Сонирхогч талуудын бүлэг нь хамтын алсын хараа эсвэл хөгжлийн төлөвлөгөө (эсвэл ижил төстэй баримт бичиг) байхгүй, Сонирхогч бүлэг нь өөрөө сонирхож байвал уурхай нь ийм төлөвлөлт эхлүүлэхэд нь эдгээр бүлэгт дэмжлэг үзүүлдэг байх. 3. Уурхай нь сөрөг нөлөөлөлд өртсөн Сонирхогч бүлэгтэй дараах ажлуудын үр дүнтэй байдлыг хянах чиглэлээр хамтран ажилладаг байх: a. Орон нутагт үр өгөөжтэй байх үйл ажиллагааг эрэмбэлэх, оновчтой байлгах . b. Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд.
------------	--

Түгээмэл асуултууд: Орон нутагт үзүүлэх нөлөө болон үр өгөөжийн менежмент

#	Түгээмэл асуултууд
2	Сонирхогч талуудын бүлэг (COI) гэж юу вэ?
3	Сонирхогч талуудын бүлгүүдтэй харилцах, оролцоог хангах, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангахын тулд тэдэнд ямар төрлийн тусламж дэмжлэг үзүүлж болох вэ?
4	Уурхайн түвшний үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн түвшний баримт бичгүүдийг ашиглах боломжтой юу?
6	Бүс нутгийн түвшний оролцоог ханган ажиллаж буй санаачлагыг үнэлгээнд хэрхэн тусгаж болох вэ?
7	Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллаж буйгаа уурхай нь хэрхэн илтгэн харуулж болох вэ?
10	Нутгийн иргэд эсвэл бусад Сонирхогч талуудын бүлэг нь уурхайтай хамтран ажиллах, оролцох сонирхолгүй эсвэл хүсэл эрмэлзэлгүй буй нөхцөлд ямар хүлээлт тавигдах вэ?
15	Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллах замаар тодорхойлж болох зорилтуудын ямар ямар жишээ байж болох вэ?
17	Уурхай хаагдсаны дараа орон нутагт үр өгөөжтэй байх санаачилгыг хэзээ ямар шатанд эхлүүлэх нь зүйтэй вэ?
18	Нийгэм, байгаль орчин, орон нутгийн аюулгүй байдал, эрүүл мэндэд үзүүлж буй бодит болон боломжит нөлөөллийг тодорхойлох үйл явцтай болохоо уурхай хэрхэн илтгэн харуулж болох вэ?
19	Бууруулах эрэмбэ (mitigation hierarchy) энэхүү протоколтой хэрхэн холбогдох вэ?
20	НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилтууд гэж юу болох, эдгээр нь энэхүү протоколын 4 дүгээр үзүүлэлтэд хэрхэн холбогдох вэ?
26	Суурь өгөгдөл гэж юу вэ?
28	Орон нутагт оруулах хувь нэмэр гэж юу вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 5: СОНИРХОГЧ БҮЛГҮҮДТЭЙ ХАРИЛЦАХ МЕХАНИЗМ

Зорилго

Сонирхогч талуудын бүлгээс (нутгийн иргэд болон байгууллагууд зэрэг) санал өгөх, асуудал илэрхийлэхэд эдгээрийг хүлээн авах, судлах болон эргэн хариу өгөх үйл явц хэрэгжсэнээр илүү бат бэх харилцаа үүсэж, итгэлцэл нэмэгдэж буйг баталгаажуулах.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
В	- Харилцах механизмын үйл явц зарим хэлбэрээр тогтсон байх. - Албан ёсны харилцах механизм үүсгэхээр төлөвлөсөн эсвэл бүрдүүлэх үйл явц хийгдэж буй (уурхайд энэхүү үйл явц бүрдээгүй буй бол).
А	- Сонирхогч бүлгүүдээс ирсэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, эдгээрийг удирдах, хариу өгөх үйл явц бүхий харилцах механизмтай байх Энэхүү механизм нь дараах функцыг багтаасан байх: - Ирсэн хүсэлт, гомдол санал, асуудлууд, өгсөн хариуг бүртгэх. - Аль гомдолд арга хэмжээ авах шаардлагатайг үнэлэн, тодорхойлох. - Цаг тухайд нь хариу өгөх. - Хүртээмжтэй байх. - Уурхай нь Сонирхогч бүлгээс илэрхийлсэн асуудлууд, эдгээрт хариу өгөх үйл явц ямар төлөвтэй байгаа, холбогдох талуудад мэдээлсэн эсэхийг бүртгэдэг байх. - Сонирхогч бүлгүүдэд уурхайн харилцах механизмыг хэрхэн ашиглах талаар урьдчилан, тодорхой мэдээлдэг байх.
АА	- Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизмыг шууд нөлөөлөлд өртөж буй сонирхогч бүлгүүдтэй хамтран боловсруулсан байх. - Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизмыг багадаа жил тутамд эргэн хянаж, тогтмол сайжруулах боломжуудыг тодорхойлдог байх.
ААА	- Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизм хангалттай хэмжээнд ажиллаагүй тохиолдолд тухайн гомдлыг дараагийн шатанд шилжүүлэн шийддэг механизмтай байх. - Харилцах механизм нь арга хэмжээ авсны дараа хэрэглэгчдэд эргэн мэдээлдэг үйл явцтай байх. - Харилцах механизмын үр дүнтэй байдлыг эргэн хянаж, сайжруулах, засан залруулах арга хэмжээ авдаг байх.

Түгээмэл асуултууд: Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизм

#	Түгээмэл асуултууд
1	Сонирхогч талуудын бүлэг (COI) гэж юу вэ?
6	Бүс нутгийн түвшний оролцоог ханган ажиллаж буй санаачлагыг үнэлгээнд хэрхэн тусгаж болох вэ?
21	Сонирхогч бүлгийн гаргасан асуудал, гомдлыг харилцах механизмын хүрээнд шийдэж чадаагүй бол энэхүү асуудлыг дараагийн шатанд шилжүүлэн шийдэх ямар механизм байж болох вэ?
26	“Ахлах удирдлагыг” хэрхэн тодорхойлох вэ?

ХАВСРАЛТ 1: ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

1. Нутгийн иргэд гэж хэн бэ?

Канадулсад 'нутгийн иргэд' гэж Хойд Америкийн нутгийн иргэд, тэдний үр садыг нийтэд нь нэрлэдэг нэршил юм. Ихэнхдээ абориген иргэд гэх хэллэгийг ашигладаг. Канадын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд абориген хүмүүсийн эрхийг заасан ба тэдний эрхийг баталгаажуулж, Анхдагч иргэд/ үндэстэн (first nation), Иннют (Innuits) болон Метис (Metis) хэмээн гурван абориген бүлгийг хүлээн зөвшөөрдөг. Эдгээр гурав нь өөр өөрийн өвөрмөц түүх, хэл, соёл, зан заншил, шүтлэг бүхий тус тусдаа бүлгүүд юм.

"Нутгийн" гэсэн үг нь олон жилийн туршид ерөнхий утга агуулгатай байсаар ирсэн. Зарим улс, бүс нутгуудад өөр үг хэллэгийг түлхүү хэрэглэдэг байж болно. Түүнчлэн зарим хувь хүмүүсийн зүгээс өөрийн гарал үүслийг тодорхойлуулах эсвэл ил болгохгүй байх сонголтыг хийж болно. Энэ тохиолдолд бусад нь тэдний сонголтыг хүндэтгэж, нутгийн иргэдийг ялгаварлан гадуурхахын эсрэг ажиллах шаардлагатай.

(НҮБ-ын Нутгийн иргэдийн асуудал хариуцсан байнгын ажиллагаатай форумын гаргасан мэдээлэл- Adapted from the United Nations Permanent Forum on Indigenous Issues Fact Sheet: https://www.un.org/esa/socdev/unpfii/documents/5session_factsheet1.pdf)

2. Сонирхогч бүлэг (COI) гэж юу вэ?

Сонирхогч бүлэг гэж (COI) уурхайн үйл ажиллагаанд хамаарах шийдвэрт ямар нэг ашиг сонирхол бүхий эсвэл уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөж буй хэмээн үзэж буй бүхий л хувь хүмүүс болон бүлгийг хэлнэ. Уурхайд хамаарах Сонирхогч талуудын бүлэгт доорх бүлгүүд багтана.

- Нутгийн иргэд
- Орон нутгийн иргэд
- Хязгаарлагдмал төлөөлөл бүхий бүлгүүд
- Уурхайн ажилтнууд
- Гэрээт гүйцэтгэгч/ ханган нийлүүлэгчид
- Хөршүүд
- Орон нутгийн байгаль орчны байгууллагууд, бусад төрийн бус байгууллагууд (ТББ)
- Орон нутгийн захиргаа, төрийн байгууллагууд

Бусад Сонирхогч талуудын бүлэгт дараах багтаж болно:

- Ханган нийлүүлэгчид
- Үйлчлүүлэгч/ худалдан авагчид
- Бүсийн болон үндэсний хэмжээний байгаль орчны байгууллагууд, төрийн бус байгууллагууд (ТББ)
- Төр, засгийн газар
- Санхүүгийн байгууллагууд
- Хувьцаа эзэмшигчид

ТУУТ (TSM) стандартын Нутгийн иргэд, орон нутгийн харилцааны протокол нь уурхайн түвшний гүйцэтгэлийг хэмжин үнэлэх зорилготой. Гэхдээ өөрийнх нь үйл ажиллагаанд ашиг сонирхол бүхий Сонирхогч талуудын бүлгийг тодорхойлохдоо орон нутгийн бүлгүүдээс давсан хүрээнд тодорхойлно. Жишээ нь хувьцаа эзэмшигчид эсвэл олборлосон бүтээгдэхүүний хэрэглэгчид (жишээ нь үнэт эдлэл үйлдвэрлэгчид) нь уурхайн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар тодорхой ашиг сонирхолтой байж болно. Түүнчлэн компани нь ханган нийлүүлэлтийн сүлжээний хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг (үйл ажиллагаанд нийлүүлж буй бүтээгдэхүүн) сайтар ойлгохын тулд ханган нийлүүлэгчдийг татан оролцуулж болно. Уурхайн зүгээс төрөл бүрийн Сонирхогч талуудын бүлгийг татан оролцуулах арга зам нь тухайн нөхцөл байдлаас хамаарна.

3. Сонирхогч бүлгүүдийн оролцоог хангах, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангахын тулд тэдэнд ямар төрлийн тусламж дэмжлэг үзүүлж болох вэ?

Зарим тохиолдолд оролцоо/хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай замын зардал эсвэл өөрийн мэдлэг, цагаа зарцуулсаныг үнэлэн мөнгөн урамшуулал зэргийг олгох нь зохистой байж болно. Мөн Сонирхогч бүлгийн төлөөлөл уурхай руу зорчихоос илүүтэйгээр компанийн төлөөлөл нь орон нутагт зорчиж Сонирхогч бүлэгтэй уулзах байдлаар дэмжлэг үзүүлж болно. Мөн тодорхой сэдвийн дагуу зөвлөх, эксперт, судалгааны материал, эсвэл орчуулгаар хангах зэрэг ч үүнд багтаж болно. Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ямар дэмжлэг тусламж хэрэгтэй байгааг нь тодорхойлвол зүйтэй.

4. Уурхайн түвшний үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн түвшний баримт бичгүүдийг ашиглах боломжтой юу?

Компанийн түвшинд ахлах удирдлагын зүгээс бичгээр гаргасан үүрэг амлалтыг (жишээ нь компанийн бодлого) үүнийг уурхайн түвшинд мөн батлан, даган мөрдөж буйг харуулах нотолгоо дагалдаж буй тохиолдолд л уурхайн түвшний өөрийн үнэлгээ эсвэл хөндлөнгийн үнэлгээнд нотлох баримт гэж үзэж болно. Компанийн баримт бичиг нь уурхайн түвшинд хамааралтай эсвэл хэрэгжиж буйг харуулсан уялдаа холбоо, баримт нотолгоо байх ёстой. Хэрэв энэхүү уялдаа холбоог үүсгэсэн бол компанийн баримт бичгийг уурхайн түвшний үүрэг амлалтын нотолгоо хэмээн үзэж болно.

5. Уурхай нь шууд нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэдийг хэрхэн тодорхойлж болох вэ?

Шууд нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэдийг тодорхойлохын тулд уурхай нь а) нутгийн иргэдийн уламжлалт газар, гэрээний эрх, болон б) газрын уламжлалт хэрэглээ, жишээ нь ан агнуур, загасчлал, тариалан зэргийн талаар ойлголттой байх шаардлагатай. Зарим компаниудын хувьд энэхүү үйл явцыг нөлөөллийн үнэлгээний хүрээнд нутгийн иргэд нөлөөнд өртөх газарт ямар эрхтэй байгааг үнэлэх замаар хийдэг.

6. Бүс нутгийн түвшний оролцоог хангах санаачлагыг үнэлгээнд хэрхэн тусгаж болох вэ?

Нэг бүс нутагт олон тооны уурхай үйл ажиллагаа явуулж буй бол компани нь Сонирхогч талуудын бүлгийг тодорхойлох, татан оролцуулахдаа бүс нутгийн арга хандлагыг сонгож болно. Энэ тохиолдолд уурхайн болон бүсийн түвшний ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой хуваарилан, баримтжуулж, үүнийг дэмжих тогтолцоог зохих шатанд нь боловсруулан, хэрэгжүүлэх шаардлагатай. ТУУТ (TSM) стандартын үнэлгээ нь тухайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй уурхай нэг бүрийн гүйцэтгэлийг үнэлэхдээ уурхайн болон бүсийн тогтолцоог харгалзан үзэх ёстой.

7. Уурхай сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллаж буйгаа хэрхэн илтгэн харуулж болох вэ?

Нутгийн иргэд, орон нутгийн харилцааны протокол бүхэлдээ Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллах, хамтран боловсруулахыг шаардсан шалгууруудыг багтаадаг. Бодит байдал дээр хамтын ажиллагаа болон хамтын боловсруулалт гэдэг нь тухайн орон нутгийн нөхцөл дэх Сонирхогч бүлгийн тэргүүлэх чиглэлүүд, ач холбогдлоос хамааран өөр өөр байна. Зарим тохиолдолд энэ нь харилцааны төлөвлөгөөг хамтран боловсруулахыг хэлж болно. Бусад газарт хамтын ажиллагаа гэдгийг уурхай нь нутгийн иргэдийн үүсгэсэн харилцаа, оролцооны үйл явцыг дэмжин хэрэгжүүлэхийг хэлж болно. Хамтын ажиллагааны талаарх харилцан хүлээн зөвшөөрсөн арга замыг Сонирхогч талуудтай зөвлөлдөн тодорхойлох нь зүйтэй.

8. Үзүүлэлт 2, АА түвшний шаардлагын хүрээнд Сонирхогч талуудын бүлэг нь харилцаа, оролцооны үйл явцыг тодорхой давтамжтайгаар хянахад өөрийн хувь нэмрийг хэрхэн оруулж болох вэ?

Уурхай нь Сонирхогч талын бүлгүүдтэй хамтран харилцаа, оролцооны үйл явцыг хянахад тухайн бүлгүүд хувь нэмэр оруулах эсвэл энэхүү хяналтад бүлгүүд хамтран ажиллах сонирхолтой эсэхийг тогтоох механизмтай байх ёстой. Сонирхогч талуудын бүлгийн зүгээс хяналтын үйл явцад оруулах хувь нэмрийн жишээнд гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг хамтран боловсруулах, үнэлгээний үйл явцад оролцох зэрэг багтаж болно.

9. Уурхай нь харилцаа, оролцоог хангах чиглэлээр хийж буй ажлаа олон нийтэд тайлагнах ямар ямар арга замууд байх вэ?

Харилцаа, оролцоог хангах чиглэлээр хийж буй ажлыг олон нийтэд тайлагнахдаа олон арга замаар хийж болно. Жишээ нь зарим компаниуд нь өөрийн компанийн тогтвортой хөгжлийн тайлангийн хүрээнд оролцоог хэрхэн хангаж буйгаа тайлагнадаг. Зарим компани нь мэдээллийн хуудас, олон нийтэд хандсан тайлан эсвэл өөрийн вэбсайтаар тайлагнадаг. Олон нийтэд хандсан тайлан нь Сонирхогч талын бүлгийн хамаарах хувь хүн бүртэй хийсэн уулзалт бүрийг баримтжуулсан баримт бичиг байх шаардлагагүй. Гэхдээ олон нийтэд тайлагнахад уурхайн зүгээс авч хэрэгжүүлж буй харилцаа, оролцоог хангах үйл ажиллагааны ерөнхий тойм, Сонирхогч талуудын сонирхож буй голлох сэдэв, чиглэл зэргийг тусгана.

10. Нутгийн иргэд эсвэл бусад Сонирхогч талуудын бүлэг нь уурхайтай хамтран ажиллах, оролцох сонирхолгүй эсвэл хүсэл эрмэлзэлгүй буй нөхцөлд ямар хүлээлт тавигдах вэ?

ТУУТ (TSM) стандартын Нутгийн иргэд, орон нутгийн харилцааны протокол нь уурхайн зүгээс гаргаж буй хичээл зүтгэл, үйл явц болон үйл ажиллагаа нь бодит харилцааг үүсгэх, хадгалан үргэлжлүүлэх жинхэнэ хүсэл сонирхол, зорилгод хөтлөгдөж буйг баталгаажуулахад төвлөрдөг. Уурхайн зүгээс хамгийн боломжит өндөр хэмжээнд хичээл зүтгэл гаргаж буй ч нутгийн иргэд эсвэл бусад Сонирхогч талуудын зүгээс төрөл бүрийн шалтгааны улмаас уурхайтай ямар нэгэн харилцаа, оролцоо, хамтын ажиллагааг үүсгээгүй байж болно. Энэ тохиолдолд уурхайг өөрийн өмнөө тавьсан зорилт, хичээл зүтгэл, үйл явц, үйл ажиллагаа нь протоколын шалгуурт нийцэж буйгаар нь үнэлнэ. Оролцоог хангах хүчин чармайлт дээр сонирхогч талууд оролцох хүсэлгүй байх нь тухайн уурхайг А-аас дээш түвшний оноо авахад саад болохгүй.

Түүнчлэн энэ протоколын хэд хэдэн шалгуур нь уурхай болон Сонирхогч талын бүлгүүдийг хамтран ажиллахыг шаарддаг. Гэвч хамтын ажиллагаа нь бүхий л тохиолдолд зөв зохистой, боломжтой байдаггүй. Жишээ нь Үзүүлэлт 2, ААА түвшин нь харилцаа, оролцооны үйл явцыг Сонирхогч талуудын бүлгүүдтэй хамтран боловсруулахыг шаарддаг. Сонирхогч талуудын бүлгүүд нь харилцаа, оролцооны үйл явцыг хамтран боловсруулах сонирхолгүй, боломжгүй байх нь бий. Энэ тохиолдолд уурхай нь Сонирхогч талуудын бүлгүүдэд харилцаа, оролцооны үйл явцыг хамтран боловсруулах боломжийг нээн өгсөн, тэрхүү үйл явц нь орон нутгийн хэрэгцээ, ашиг сонирхлыг харгалзсан байсныг илтгэн харуулна. Сонирхогч талуудын бүлгүүдийн зүгээс хамтран ажиллах хүсэл сонирхолгүй байх нь тухайн уурхай хамаарах гүйцэтгэлийн түвшнийг ханган биелүүлэхэд саад болохгүй.

11. Тодорхойлон гаргасан Сонирхогч бүлгүүдээс хязгаарлагдмал төлөөлөл бүхий хэмээн тогтоосон бүлгийг харгалзан үздэг гэдгээ хэрхэн илтгэн харуулах вэ?

Энэхүү протоколын үндсэн зорилго нь уурхай нь Сонирхогч бүлэгтэй харилцах боломж бий болгож буй эсэх, үүнд эмзэг байдлын хувьд өндөр эрсдэл бүхий тодорхой бүлэгт хамаарах хувь хүн эсвэл хүн амд хандан уурхайтай харилцах, оролцох боломжийг нь хангах зорилгоор бүх Сонирхогч талуудын бүлэгт хүртээмжтэй, нээлттэй харилцаа, оролцооны үйл явцыг бий болгосон эсэхийг баталгаажуулах явдал юм. Ингэхийн тулд уурхай нь Сонирхогч талуудын бүлгийн хэрэгцээнд нийцүүлэх, харилцаа, оролцооны үйл явцыг төлөвлөхдөө олон нийтийн оролцоог хангах, үүний зэрэгцээ тэдний соёлын хэрэгцээг хүндэтгэх, хүртээмжтэй байх нөхцөлүүдийг бүрдүүлэх хэрэгтэй. Энэхүү протоколын зорилго нь компаниуд харилцаа, оролцоог аль болох иж бүрэн байдлаар хэрэгжүүлж байхыг хөхиүлэн дэмжих явдал байна. Энэ нь зарим тохиолдолд өргөн хүрээний Сонирхогч талуудын бүлэгт хамаарах асуудлуудыг (жишээ нь эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, ашгийн бус дэмжлэг туслалцаа гэх мэт) авч үзэхийг хэлж болно. Бусад тохиолдолд тодорхой бүлэг эвсэл хувь

хүмүүст шууд хандсан ганцаарчилсан дэмжлэг байж болно. Бүх Сонирхогч бүлэг уурхайтай хамтран ажиллах, оролцох сонирхолгүй байж болно. Гэхдээ уурхайн зүгээс шууд болон сөрөг нөлөөнд өртөж буй талуудтай харилцах, оролцох боломжийг нь нээлттэй байлгах, мөн түүнчлэн эдгээр боломжийг олон нийтэд мэдээлдэг (жишээ нь компанийн вэбсайт, сонин эсвэл орон нутагт түгээх мэдээллийн хуудас) гэдгээ баталгаажуулсан байх ёстой.

Уурхай нь Сонирхогч бүлгийн зүгээс гаргасан нууцлалыг хангах хүсэлтийг, үүнд хязгаарлагдмал төлөөлөл бүхий бүлгийн зүгээс гаргасан хүсэлтийг хангах зүйл заалтыг өөрийн баримт бичигт багтаасан байх шаардлагатай.

12. Уурхай нь албан ёсны гэрээ (жишээ нь Нөлөөлөл, үр өгөөжийн гэрээ) байхгүй тохиолдолд үзүүлэлт 3 AAA түвшнийг хангаж буйгаа хэрхэн илтгэн харуулж болох вэ?

Үзүүлэлт 3, Түвшин AAA нь тухайн уурхай нь нутгийн иргэдийн өмнө хүлээсэн үүрэг амлалт, гэрээ хэлцлийн нөхцөлүүдийг хангаж, үүний хэрэгжилтэд хяналт хийж байхыг шаарддаг. Энэхүү шалгуурын үндсэн зорилго нь тухайн уурхай нутгийн иргэдэд хандан өөрийн авсан үүрэг амлалтыг биелүүлж буй эсэхийг баталгаажуулахад оршдог. Нөлөөллийн менежментийн гэрээ, Оролцооны гэрээ, Нөлөөлөл, үр өгөөжийн гэрээ, Нийгэм эдийн засгийн гэрээ, Байгаль орчны гэрээ гэх мэт албан ёсны гэрээ хэлцлийг энэхүү шалгуурт нийцсэн болохыг харуулан нотолгоо байдлаар ашиглаж болохын зэрэгцээ албан ёсны гэрээгүй байсан ч уурхай нь AAA түвшнийг хангах боломжтой.

13. Уурхай нь үзүүлэлт 3 (Түвшин А- AAA) дээрх сургалт, мэдлэгтэй хамаарах шалгуурыг хангахын тулд бүх ажилтнууддаа ижил түвшний сургалт хийх шаардлагатай юу?

Үзүүлэлт 3 дээрх шалгуурууд нь Канадын Үнэн бодит байдал, эвлэрлийн комиссын (Truth and Reconciliation Commission) зүгээс компаниудад хандан гаргасан 92 iii тоот уриалгын хэрэгжилтийг хангах зорилготой. Энэхүү уриалга нь:

- Удирдлага болон ажилтнууддаа абориген иргэдийн түүхийн талаарх мэдлэг, боловсрол олгох, үүнд орон нутгийн суурин сургуулиудын түүх болон үлдээж буй өв, НҮБ-ын Нутгийн иргэдийн эрхийн тухай тунхаг, абориген иргэдийн эрхийн тухай гэрээ, тэдний эрх, нутгийн иргэдийн тухай хууль, нутгийн иргэд болон эрх баригчдын харилцаа зэрэг сэдэв багтсан байвал зохистой. Үүний хүрээнд соёлын ялгаатай байдал, хүний эрх болон арьсны өнгөөр ялгаварлахын эсрэг сэдвүүдээр ур чадварт суурилсан сургалтуудыг хийх шаардлагатай.

Энэхүү уриалгын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь уурхай бүрт өөр өөр, олгож буй мэдлэг, сургалтын цар хүрээ нь байгууллага доторх албан тушаал бүрээр ялгаатай байж болно. Жишээ нь удирдлага болон томилогдсон ажилтнуудад олгож буй мэдлэг, сургалтын хөтөлбөр нь (А түвшин) тухайн ажилтанууд орон нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй, зөв

зохистой харилцахад шаардлагатай мэдлэг багтана. Нөгөө талаар богино хугацааны ажилтнуудад хийж буй мэдлэг олгох сургалтыг уурхайтай танилцуулах багц сургалтад багтааж болно.

Нутгийн иргэдийн түүхийн талаар мэдлэг, сургалтыг уламжлалт танхимын сургалтаар хязгаарлах шаардлагагүй. Зарим компаниуд нь нутгийн иргэдийн кино, жүжгээр дамжуулан мэдлэг, боловсрол олгох, нутгийн иргэдийн протоколыг бизнесийн үйл ажиллагаанд нэгтгэн уялдуулах, орон нутгийн арга хэмжээнд ажилтнуудынхаа оролцоог дэмжих зэрэг хэлбэрээр зохион байгуулсан жишээ байдаг.

Энэхүү протокол нь уурхайнууд өөрийн ажилтнуудыг соёлын ялгаатай байдал, зөрчилдөөн шийдвэрлэх, хүний эрх, ялгаварлан гадуурхахаас ангид байх зэрэг чиглэлээр мэдлэг, ур чадвартай болгоход түлхэц үзүүлэх зорилготой. Зарим тохиолдолд ажилтнууд нь шаардлагатай мэдлэг ур чадвартай байдаг бол зарим тохиолдолд уурхай нь ур чадварт суурилсан сургалт, соёлын ялгаатай байдлын мэдлэг, оролцооны сургалтуудыг хийх шаардлагатай байдаг. Ямар ч санаачилга байгууллагын болон хувь ажилтны хэрэгцээнд үндэслэнэ. Сургалтын агуулга эсвэл хэрхэн зохион байгуулахад бүх нөхцөлд таарах нэг арга зам гэж байхгүй.

Үзүүлэлт 3 дээр AAA түвшнийг хангахын тулд мэдлэг олгох үйл явц болон/эсвэл сургалтын хөтөлбөрийг нутгийн иргэдтэй хамтран боловсруулан хэрэгжүүлдэг гэсэн баримт нотолгоо шаардлагатай. Үүнд контент хөгжүүлэхэд хамтран ажиллах, нутгийн иргэдтэй хамтран мэдлэг олгох/сургалт зохион байгуулах, мэдлэг эзэмшигчдийг (Knowledge Holders) олж тодорхойлох зэрэг багтаж болно. Зарим тохиолдолд нутгийн иргэдтэй ямар нэг байдлаар хамтран ажиллах боломжгүй байх нь бий. Ийм нөхцөлд уурхай нь хамаарах орон нутаг, иргэдтэй хамтран ажиллах чиглэлээр хүчин чармайлт гаргасан болохоо илтгэн харуулах шаардлагатай. Уурхай нь өөрийнхөө сургалтын материалд орон нутгийн нөхцөл байдлыг тусган оруулсан гэдгээ баталгаажуулах шаардлагатай.

AAA түвшин нь нутгийн иргэдийн түүх, уламжлал, эрхийн талаарх мэдлэгийг сайжруулахад манлайлал үзүүлж байхыг шаардана. Үүнийг хангах нэгаргануурхайнажилтнуудад зориулан боловсрол, сургалт, мэдлэг олгох санаачилга, сургалтыг зохион байгуулах явдал юм. Гүйцэтгэлийг үнэлэхийн тулд зохион байгуулж буй сургалт бүх ажилтнуудад тогтмол хүрч буй эсэхийг нотлон харуулах шаардлагатай. ТУУТ (TSM) стандартын хөндлөнгийн үнэлгээ хийхдээ компанийн бүхий л ажилтнууд сургалтанд оролцсон эсэхийг үнэлэх шаардлагагүй.

14. Нутгийн иргэдийн харилцаа, оролцоо, зохицуулалтын хүрээнд тавигдах мэдлэг, ур чадвартай гэдгээ хэрхэн илтгэн харуулах вэ?

Тухайн ажилтан нь шаардлагатай мэдлэг, ур чадвартай эсэхийг дараах болон бусад хүчин зүйлсийг харгалзан тодорхойлж болно:

- Энэ чиглэлээр зохион байгуулсан сургалтад суусан байдал, мөн боловсрол эзэмшсэн байдал

- Энэ чиглэлээрх туршлага, үүнд харилцаа, оролцооны протоколыг хэрэглэж байсан болон зөвлөлдөх ажил зохион байгуулсан туршлага
- Шаардлагатай мэдлэгийн түвшин
- Орон нутагтай тогтоосон харилцаа, холбоо

15. Сонирхогч бүлэгтэй хамтран тодорхойлж болох зорилтуудын ямар ямар жишээ байж болох вэ?

Харилцан зөвшилцсөн зорилтуудад орон нутгийн боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн боломжууд, худалдан авалт, эдийн засгийн хөгжлийн төслүүд, байгаль орчны хамгаалах төслүүд, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах зэрэг бусад зорилтууд багтаж болно.

16. Нутгийн иргэдийн амьдардаг газар нутгаас хол байрлах уурхай нь Үзүүлэлт 3 дээрх шалгууруудыг хангаж буйгаа хэрхэн нотлох вэ?

Үзүүлэлт 3, А, АА болон ААА түвшнийг хангахын тулд уурхайн зүгээс авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь уурхай бүрээр ялгаатай. Харилцаа болон оролцооны үйл явц нь тухайн орон нутгийн нөхцөл байдал, нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл зэргийг тусгасан байна. Зарим уурхай нь нутгийн иргэдэд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлдэггүй болон/эсвэл нутгийн иргэдийн зүгээс ямар нэгэн оролцоог шаардаагүй ч протоколыг хэрэгжүүлэх тохиолдол байдаг. Бусад тохиолдолд компаниуд нь нутгийн иргэдтэй харилцан, оролцоог хангахаар оролдлого хийсэн ч иргэдийн зүгээс ямар нэгэн хариу өгөхгүй байж болох юм. Нутгийн иргэдэд үзүүлж буй нөлөөлөл бага, үл мэдэгдэм бол уурхай нь энэхүү үзүүлэлтийн зарим шалгуурыг үл хамаарна гэж үзэж болно. Нутгийн иргэдэд үзүүлж буй нөлөөллийн хэмжээнээс үл хамааран уурхай нь АА эсвэл ААА үнэлгээ авахын тулд дараах зүйлсийг илтгэн харуулах шаардлагатай. Үүнд:

- Уурхайн ойр орчимд амьдран суудаг нутгийн иргэдийн талаар болон тэдэнд үзүүлж буй нөлөөллийн хэмжээ, цар хүрээний мэдээлэлтэй үүнийгээ баримтжуулсан байх.
- Уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртөж буй нутгийн иргэд өөрсдөө сонирхвол уурхайн зүгээс зохион байгуулж буй харилцаа, оролцооны үйл ажиллагаанд оролцох боломж нээлттэй, хүртээмжтэй байх.
- Компанийн зүгээс бий болгож буй боломжууд нь нутгийн иргэдэд тэгш, хүртээмжтэй байхаар зохион байгуулсан байх.
- Нутгийн иргэдийн оролцоог хангах, тэдний талаар мэдлэг мэдээлэл өгөх хөтөлбөр хэрэгждэг байх (Үзүүлэлт 3).
- Нутгийн иргэд, орон нутгийн иргэдтэй харилцах, оролцоог хангах талаар гаргасан санал санаачлага, хүчин чармайлтаа баримтжуулсан байх.

Хэрэв уурхай нь АА эсвэл ААА түвшин дээр үзүүлэлт 3 үл хамаарна гэсэн бол холбогдох тайлбарыг ТУУТ стандартын явцын тайланд оруулан олон нийтэд нээлттэй тайлагнах үүрэгтэй.

17. Уурхай хаагдсаны дараа орон нутагт үр өгөөж өгөх санаачилгыг хэзээ ямар шатанд эхлүүлэх нь зүйтэй вэ?

Энэхүү протоколыг хэрэгжүүлж буй зарим компаниуд нь олон арван жилийн туршид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулдаг. Энэ тохиолдолд уурхай хаагдсаны дараа хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн орон нутагтай хэлэлцэх нь тийм ч оновчтой биш байж болно. Гэхдээ тэргүүлэх ач холбогдол бүхий санаачилгуудыг Сонирхогч бүлгийн оролцоотойгоор тодорхойлох шаардлагатай.

18. Уурхай нь нийгэм, байгаль орчин, орон нутгийн аюулгүй байдал, эрүүл мэндэд үзүүлж буй бодит болон боломжит нөлөөллийг тодорхойлох үйл явцтай болохоо хэрхэн илтгэн харуулж болох вэ?

Уурхай нь бодит болон боломжит нөлөөллийн талаар Сонирхогч бүлэгтэй үр дүнтэй харилцахын тулд өөрийн үйл ажиллагаанаас гарч буй сөрөг нөлөөллийн талаар сайтар судалсан байх ёстой.

Уурхай нь бодит болон боломжит сөрөг нөлөөллийг тодорхойлох ажлыг эрсдэлийн үнэлгээ хийх явцад хамт хийж болно. Жишээ нь уурхай нь ТУУТ (TSM) стандартын Хямралын менежмент, мэдээлэл харилцааны протоколд буй боломжит аюул, эрсдэлүүдийг тодорхойлсон байх шаардлагыг ханган биелүүлэхдээ энэ асуудлыг хамтатгаж болно.

Уурхай нь мөн тодорхойлон гаргасан нөлөөлөл бүрт хамаарал эсвэл ашиг сонирхол бүхий Сонирхогч талуудын бүлгийг тодорхойлох ёстой. Энэхүү үйл явцыг Үзүүлэлт 1 дээр заасан Сонирхогч бүлгийг тодорхойлох ажилтай уялдуулан нэгтгэж болно.

Жишээ нь хаягдлын менежментийн нөлөөнд өртөж болох бүлэг, хүмүүс:

- Хаягдлын байгууламж гэмтэх тохиолдолд шууд нөлөөлөлд өртөх хүмүүс.
- Хаягдлын байгууламжийн үйл ажиллагаанаас гарах нөлөөлөлд өртөх хүмүүс.

Уурхай бүр дээр, орон нутаг бүр дээр ашиг сонирхол болон ач холбогдол өгөх асуудлууд өөр өөр байна. Иймд сонирхогч бүлэгтэй харилцаа, оролцооны сэдэв, чиглэлийг хамтдаа хэлэлцэн тодорхойлох хэрэгтэй. Жишээ нь Хаягдлын менежментийн хувьд Сонирхогч бүлгийн ач холбогдол өгөх сэдвүүдэд дараах асуудлууд багтаж болно:

- Онцгой байдлын бэлэн байдал, авах арга хэмжээний төлөвлөлт
- Хаягдлын нөхцөл байдал (тухайлбал хүчил үүсгэдэг эсэх)
- Байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл
- Хаалт болон нөхөн сэргээлт

- Орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд
- Хууль зохицуулалтын шаардлагууд болон зөвшөөрөл олгох үйл явц
- Шинэ уурхай, өргөтгөлийн зураг төсөл, төлөвлөлт
- Усны хэрэглээ, чанар
- Тоосжилт бууруулах механизм
- Газар орчны харагдах байдлын нөлөөлөл (visual impact)
- Үүрэг хариуцлага, эргэн тайлагнал
- Мониторингийн арга ажиллагаа болон үр дүн
- Уламжлалт газар ашиглалт
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цаг уурын гэнэтийн үзэгдэлд бэлэн байх.

19. Бууруулах эрэмбэ (mitigation hierarchy) энэхүү протоколтой хэрхэн холбогдох вэ?

Бууруулах эрэмбэ гэж ямар төслийн зүгээс биологийн олон янз байдалд үзүүлэх эрсдэл, боломжит сөрөг нөлөөллийг удирдахад ашигладаг хэрэгсэл юм. Бууруулах эрэмбийн зарчмыг бусад нөлөөллийг удирдахад ашиглах боломжтой. Уурхай нь үйл ажиллагааны улмаас гарах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө боловсруулахдаа юуны өмнө урьдчилан сэргийлэх/ зайлсхийхийг тэргүүлэх чиглэл болгоно. Тухайн сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх боломжгүй үед дараагийн шатны буюу нөлөөллийг бууруулах эсвэл нөхөн сэргээх/ дүйцүүлэх арга хэмжээг авна. Урьдчилан сэргийлэх/ зайлсхийх арга хэмжээ гэдэг нь сөрөг нөлөөлөл гарах үйл ажиллагааг эхлүүлэх эсвэл шийдвэр гаргахаас өмнө тухайн нөлөөллийг урьдчилан таамаглах болон сэргийлэхийг хэлнэ. Сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд төслийн анхан шатны төлөвлөлтөд өөрчлөлт оруулан гарч болох эрсдэл болон нөлөөллийг гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ. Хэрэв сэргийлэх боломжгүй бол дараагийн шатны нөлөөлөл бууруулах арга замаас хамгийн зохистойг сонгоно.

(Олон улсын уул уурхай, металлын зөвлөл- ICMM A cross-sector guide for implementing the Mitigation Hierarchy <https://www.icmm.com/website/publications/pdfs/biodiversity/cross-sector-guide-mitigation-hierarchy>).

20. НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) гэж юу болох, эдгээр нь энэхүү протоколын 4 дүгээр үзүүлэлтэд хэрхэн холбогдох вэ?

Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs), зарим тохиолдолд Олон улсын хөгжлийн зорилтууд хэмээн нэрлэгддэг эдгээр зорилтуудыг НҮБ-ын гишүүн орнууд анх 2015 онд батлан гаргаж, 2030 он гэхэд олон улсын хэмжээнд ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалах, энх тайван, хамтын хөгжилд хүрсэн байх олон улсын зорилтуудыг гаргасан.

Нийт 17 зорилт нь хамтад нь авч үзвэл нэг салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь бусад газарт хийгдэж буй үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх ба хөгжлийн үйл явц нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой байдлын тэнцлийг хангах шаардлагатайг бүрэн хүлээн зөвшөөрдөг (<https://www.undp.org/content/undp/en/home/sustainable-development-goals.html>).

2030 он гэхэд ТХЗ-уудыг хүрэхийн тулд төр засгийн газрууд, ТББ-ууд, хөгжлийн түншлэгч байгууллагууд, ард иргэд, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа шаардагдана.

ТХЗ-ууд нь уурхай нь өөрийн үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, сөрөг нөлөөллөөс сэргийлэх болон бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, орон нутаг, иргэдэд очиж буй үр өгөөжийг нэмэгдүүлэх үр дүнтэй арга аргачлал юм.

21. Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизм хангалттай хэмжээнд ажиллаагүй тохиолдолд тухайн гомдлыг дараагийн шатанд шилжүүлэн шийддэг механизмийн жишээ юу вэ ?

Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизмын хүрээнд асуудал шийдэгдээгүй бол уурхай болон Сонирхогч бүлэг нь төвийг сахисан, талуудын хүндлэлийг хүлээсэн гуравдагч талтай (жишээ нь шашны байгууллагын тэргүүн, ахмад настан эсвэл туршлагатай эвлэрүүлэн зуучлагч) хамтран харилцан хүлээн зөвшөөрөхүйц шийдлийг гаргах нь зүйтэй. Хэрэв тухайн гомдол нь техникийн шинж чанартай бол хөндлөнгийн хараат бус мэргэжилтэний дүгнэлтийг гаргуулан ашиглаж болно.

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

22. “Тодорхой, ойлгомжтой” гэж юу гэсэн утгатай вэ?

Тодорхой, ойлгомжтой гэж Сонирхогч талуудын бүлгийн боловсролын түвшинд тохирсон харилцахад ойлгомжтой, ямар нэгэн техникийн үг хэллэг агуулаагүй байхыг ойлгоно.

23. “Чадавх бүрдүүлэх” гэж ямар утгатай вэ?

Чадавх бүрдүүлэх гэж хувь хүний, байгууллагын, байгууллага хоорондын, системийн түвшинд хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих, нөөц эх үүсвэрээр хангах замаар Сонирхогч талуудын бүлгийг уурхайн үйл ажиллагаанд оролцуулах, мэдээлэл дамжуулах үйл явцыг хэлнэ.

24. “Харилцаа” болон “хэлэлцүүлэг” гэж юу вэ?

Харилцаа, оролцооны үйл явцад Сонирхогч бүлгүүд хэрэгтэй байгаа мэдээ, мэдээллээ авах, уурхай нь харилцаж буй талуудад ойлгомжтой байдлаар мэдээ мэдээллээ хүргэх 2 талын харилцаа юм. Хэлэлцүүлэг нь оролцогчдыг хамтын ойлголтод хөтөлдөг мэдээлэл харилцааны хэлбэр юм.

25. “Ахлах удирдлагыг” хэрхэн тодорхойлох вэ?

Энэхүү протоколын хувьд ахлах удирдлага гэж компанийн болон/эсвэл уурхайнтүвшиндэххарилцаа,оролцоо,хэлэлцүүлгийнүйл явцыгхариуцсан албан тушаалтныг хэлнэ. Олон уурхай бүхий томоохон компанийн хувьд орон нутагтай харилцах нь орон нутгийн, бүсийн, үндэсний зэрэг өөр өөр түвшинд явагддаг тул тухайн түвшин бүрийн хариуцсан ажилтныг ахлах удирдлага гэж үзнэ.

26. Суурь өгөгдөл гэж юу вэ?

Суурь өгөгдөл гэж уурхайн бүтээн байгуулалтаас өмнө цуглуулсан өгөгдөл мэдээллийг хэлнэ. Нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийн хувьд суурь мэдээлэлд нийгмийн нөхцөл байдал, нийгмийн сайн сайхан байдал, сонирхогч талуудын бүлгийн нийгмийн үйл ажиллагаа зэрэг багтана. Суурь өгөгдлийн хамрах хүрээ нь тухайн уурхайн нөхцөл байдалд нийцсэн, сонирхогч бүлгийн саналыг харгалзсан, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үр ашигтай, бодит арга замаар дүн шинжилгээ хийхэд дэмжлэг болох үзүүлэлт, мэдээллийг багтаасан байх ёстой. Бүхий л уурхайд суурь өгөгдөл байхгүй байж болохыг харгалзан тухайн уурхай нь өөр бусад аргыг сонгон ашиглаж болно. Жишээ нь уурхай ерөнхий чиг хандлагыг суурь мэдээлэл ашиглан болгох замаар сөрөг нөлөөллийн чиг хандлага болон нөлөөлөл бууруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнгийн талаар үнэлгээ хийж болно. Түүнчлэн уурхайд нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх бүх өгөгдөл, мэдээлэл байхгүй байж болно.

27. Орон нутгийн болон нутгийн мэдлэг гэж юу вэ?

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын (ЮНЕСКО) зүгээс орон нутгийн болон нутгийн мэдлэгийг дараах байдлаар тодорхойлдог:

- Орон нутгийн болон нутгийн мэдлэг гэж тухайн ард иргэд оршин сууж буй байгаль дэлхийтэйгээ олон зуун жилийн түүхийн туршид бий болсон ойлголт, ур чадвар, философийг хэлнэ. Орон нутгийн болон нутгийн иргэдийн хувьд орон нутгийн мэдлэг нь өдөр тутмын амьдралдаа шийдвэр гаргахад хэрэг болдог гол мэдээлэл байдаг.
- Энэхүү мэдлэг нь соёлын олон талт байдалтай уялдаатайн зэрэгцээ тухайн улсын хэл, нийгмийн давхраажилт, байгалийн нөөц ашиглах арга барил, нийгмийн харилцаа, шашин шүтлэг, оюун санааг мөн агуулж байдаг.
- Эдгээр өвөрмөц мэдлэг нь дэлхийн соёлын олон талт байдлын чухал хэсэг байх ба орон нутгийн онцлогт нийцсэн тогтвортой хөгжлийг хангах үндэс суурь болно. (UNESCO, Local and Indigenous Knowledge Systems: <http://www.unesco.org/new/en/natural-sciences/priority-areas/links/related-information/what-is-local-and-indigenous-knowledge>)

28. Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр гэж юу вэ?

Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр гэж орон нутгийн иргэдэд үр өгөөж өгөх зорилгоор хийгдэж буй бүхий л ажлыг багтаан ойлгоно. Үүнд орон нутагт өгөх хандив тусламж, орон нутгийн хөгжлийн санаачилгуудад хийх хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа болон хөдөлмөр эрхлэлтийн санаачилгууд, ур чадварын сургалт, боловсролын хөтөлбөр зэрэг багтана.

ХАВСРАЛТ 2: ТУУТ СТАНДАРТЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГАХ ХУУДАС

Нутгийн иргэд, орон нутгийн харилцаа

Уурхайн нэр:		Компанийн нэр:	
Үнэлгээ хийсэн ажилтаны нэр:		Хүргүүлсэн огноо:	

Дэмжих баримт бичиг/ Нотолгоо:	
Баримт бичгийн нэр	Байршил

Ярилцлагад хамрагдсан хүмүүс:			
Нэр	Албан тушаал	Нэр	Албан тушаал

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 1: СОНИРХОГЧ БҮЛГҮҮДИЙГ (СОI) ТОДОРХОЙЛОХ					
Үзүүлэлт 1 Түвшин В	1.	Зарим Сонирхогч бүлгийг олж тодорхойлсон уу?			
	2.	Сонирхогч бүлгийг тодорхойлох үйл явц бүрдсэн үү?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 1 Түвшин А	1.	Уурхайн түвшинд талуудын олон төрлийн ашиг сонирхол, санаа зовж буй асуудлыг тодорхойлон гаргахад туслах сонирхогч бүлгийг тодорхойлох, баримтжуулсан үйл явц бүрдсэн байх			
	2.	Үйл явцад дараах багтсан уу ?			
	a.	Сонирхогч бүлгүүдэд зориулсан өөрсдийгөө тодорхойлох механизм байна уу ?			
	b.	Тодорхойлон гаргасан Сонирхогч бүлгүүдийн талаар мэдээлэлтэй, энэ нь тогтмол шинэчлэгддэг үү ?			
	c.	Сонирхогч бүлгийн зүгээс хүсэлт гаргасан тохиолдолд нууцлалыг хадгалах зүйл заалт байна уу?			
	3.	Уурхайн үйл ажиллагаа явуулах бүхий л хугацааны туршид Сонирхогч бүлгийг тодорхой давтамжтайгаар дахин эргэн авч үздэг үү?			
	4.	Уурхайн нь өөрийн тодорхойлсон Сонирхогч талуудын бүлгүүдийн жагсаалтыг гаргаж, байнга хянаж, шинэчилдэг үү?			
Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.					

Үзүүлэлт 1 Түвшин АА	1.	Баримтжуулсан үйл явц нь доорх бүлгийг тодорхойлох талаар багтаасан уу?				
	a.	Орон нутаг дахь хязгаарлагдмал төлөөлөл бүхий Сонирхогч талуудын бүлгүүд?				
	b.	Уурхайн үйл ажиллагаанаас ашиг сонирхолд нь шууд бус нөлөөлөлд орох эсвэл тодорхой асуудалд суурилсан Сонирхогч талуудын бүлгүүд (жишээ нь улсын хэмжээний, орон нутгийн, олон улсын ТББ)?				
	2.	Уурхайн зүгээс Сонирхогч талуудын бүлгийг хэрхэн тодорхойлж буй дээр саналаа өгөхийг эдгээр бүлгүүдэд хандан урьдаг уу?				

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
		Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.			
Үзүүлэлт 1 Түвшин ААА	1.	Сонирхогч талуудын бүлгийг тодорхойлох системийг тодорхой хугацаанд, эдгээр бүлгүүдтэй хамтран эргэн харж, байнга сайжруулж байх боломжийг бүрдүүлсэн үү?			
	2.	Сонирхогч бүлгүүдийн өгсөн саналыг Сонирхогч талуудын бүлгийг тодорхойлох үйл явцыг шинэчлэхэд харгалзан үздэг үү?			
	a.	Сонирхогч талуудын бүлгийн саналыг харгалзаагүй бол ямар шалтгааны улмаас тухайн саналыг тусгаагүй болохоо эргэн Сонирхогч бүлгүүдэд тайлбарладаг уу?			
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайг ААА түвшинд хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.				
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 1 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ			Түвшин:_____		

АСУУЛТ		T	Y	NA	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 2: СОНИРХОГЧ ТАЛУУДЫН БҮЛГИЙН ҮР НӨЛӨӨТЭЙ ОРОЛЦОО БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ					
Үзүүлэлт 2 Түвшин В	1.	Уурхай нь шаардлагатай/ зохистой үед Сонирхогч бүлгүүдтэй харилцах, хэлэлцүүлгийн үйл явцад оролцох боломжоор ханган туслалцаа үзүүлдэг үү?			
	2.	Сонирхогч бүлгийн харилцаа болон хэлэлцүүлгийн талаар дотоод тайлагнал хааяа хийгддэг үү?			
	3.	Сонирхогч бүлгүүдтэй харилцах үйл явц зарим талаар явагдаж, хааяа хэлэлцүүлэг хийдэг үү ?			
	4.	Сонирхогч бүлгүүдтэй харилцах албан ёсны үйл явцыг хөгжүүлсэн үү ?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 2 Түвшин А	1.	Сонирхогч бүлгүүдтэй харилцах, хэлэлцүүлэг хийх үйл явцыг тэдний оролцоотойгоор боловсруулж, баримтжуулсан үйл явц тогтсон ?			
	2.	Сонирхогч бүлгүүдтэй хэрхэн харилцаж буй талаарх үр дүнг ахлах удирдлага болон нөлөөнд өртөж буй Сонирхогч талуудын бүлгүүдтэй хамтран байнга, урьдчилан тогтоосон давтамжтайгаар эргэн хянах үйл явц бүрдэн тогтсон уу?			
	3.	Мэдээлэл харилцаа нь Сонирхогч талуудын бүлгийн хэл дээр бичигдсэн (хэрэв хүсэлт гаргасан бол), Сонирхогч талуудын бүлгүүдэд тодорхой, ойлгомжтой байдлаар бичигддэг үү?			
	4.	Хамаарах материалуудыг Сонирхогч талуудын бүлэгт хянуулахаар хүртээмжтэй, цаг тухайд нь гарган өгдөг үү?			
	5.	Сонирхогч талуудын бүлгийг сонирхож буй асуудал, санаа зовних зүйлсийн талаар үр дүнтэйгээр оролцох боломжийг нь хангахын тулд Сонирхогч талуудын бүлгийн чадавхыг бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлох үйл явц бүрдэн тогтсон уу?			
	6.	Томилогдсон ажилтнуудад соёлын ялгаатай байдал, харилцаа, оролцоо, хэлэлцүүлгийн талаарх сургалтыг хийсэн үү ?			

АСУУЛТ		T	Y	NA	Тайлбар ба нотолгоо
	7.	Сонирхогч талуудын бүлэгтэй харилцах, оролцооны талаар олон нийтэд мэдээлдэг үү ? Үүнд тайлант хугацаанд хийгдсэн харилцааны төрөл, хөндөгдсөн сэдэв зэргийг тусгадаг уу?			
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 2 Түвшин АА	1.	Харилцаа, оролцооны үйл явцыг Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран эргэн хянаж, бүлгүүд нь асуудал, боломжуудыг тодорхойлоход үр дүнтэй оролцох, өөрсдийнх нь ашиг сонирхолыг хөндөх шийдвэрүүдэд нөлөөлөх боломжийг ханган баталгаажуулдаг уу?			
	2.	Уурхай нь Сонирхогч талуудын бүлэгтэй тогтмол харилцдаг, тэдний бодит оролцоог ханган ажилладаг туршлагатай юу			
	3.	Харилцаа холбооны үйл явц нь хязгаарлагдмал төлөөлөлтэй хэмээн тогтоосон Сонирхогч талуудын бүлгийг оролцуулдаг уу ?			
	4.	Яриа хэлэлцүүлэгт үр дүнтэй оролцох боломжийг хангахын тулд Сонирхогч талуудын бүлгүүдийн чадавхыг бүрдүүлэх үйл явц тогтсон уу?			
	5.	Сонирхогч талуудын бүлэг нь байнгын сайжруулалт хийх зорилгоор харилцаа, оролцооны үйл явцын хяналтад оролцон хувь нэмэр оруулдаг уу?			
	6.	Харилцаа, оролцоо болон үр дүнгийн талаарх Сонирхогч талуудын бүлгийн санал, бодлыг идэвхтэй эрэлхийлж, олон нийтэд тайлагнадаг уу?			
	7.	Олон нийтийн тайлагналд Сонирхогч талуудын бүлэг саналаа илэрхийлэх боломж нээлттэй байдаг уу?			
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 2 Түвшин ААА	1.	Харилцаа, оролцооны үйл явцыг Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран боловсруулдаг уу ? Мөн зөрчил шийдэх механизмыг багтаасан байдаг уу?				
	2.	Сонирхогч талуудын бүлэг нь тэдэнд шууд сөрөг нөлөө үзүүлж буй болон/эсвэл ашиг сонирхол бүхий харилцан тохирсон асуудлаар хамтарсан шийдвэр гаргахад оролцдог уу?				

АСУУЛТ			Т	Ү	НА	Тайлбар ба нотолгоо
	3.	Харилцаа, оролцооны системийн үр дүнтэй байдлын хяналтыг Сонирхогч талуудын бүлгүүдтэй хамтран хийж, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг үү?				
	4.	Олон нийтэд тайлагнахад оролцоог хангах системийн үр дүнтэй байдлын талаарх мэдээллийг багтаан тусгадаг уу?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайг ААА түвшинд хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ			Түвшин:_____			

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 3: НУТГИЙН ИРГЭДТЭЙ ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦДАГ БАЙХ					
Үзүүлэлт 3 Түвшин В	1.	Нутгийн иргэдтэй харилцан, оролцоог нь хангахаа илтгэн харуулж буй үүрэг амлалт, эрмэлзэл нь тодорхой байна уу ?			
	2.	Шууд нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй харилцах зарим үйл явц бүрдэж, яриа хэлэлцүүлэг заримдаа хийгддэг үү ?			
	3.	Нутгийн иргэдэд ямар асуудал чухал болохыг тодорхойлох зорилгоор тэдэнтэй харилцдаг, хэлэлцүүлэг өрнүүлэхэд татан оролцуулах үйл явцыг боловсруулж (эсвэл хэрэгжүүлж) байна уу ? Ингэхдээ орон нутгийн хэл, заншил, хууль тогтоомжийг судлан ашигладаг уу ?			
	4.	Томилогдсон ажилтнуудын чадамжийг хангах болон/эсвэл дараах чиглэлээр сургалт хийх үйл явцыг боловсруулж (эсвэл хэрэгжүүлж) байна уу :			
	a.	Зөвлөлдөх арга хэмжээний шаардлагуудыг хангадаг уу ?			
	b.	Сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн түүх, уламжлал болон эрхийн талаар?			
	c.	Соёлын ялгаатай байдлын талаарх мэдлэг, мэдрэмжтэй харилцаа			

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.					
Үзүүлэлт 3 Түвшин А	1.	Ахлах удирдлагын зүгээс нутгийн иргэдийн харилцаа, оролцооны чиглэлээр ТУУТ (TSM) стандартын Уул уурхай, нутгийн иргэдийн хүрээллийн дагуу өөрийн үүрэг амлалт/ хичээл зүтгэлийг илтгэн харуулсан байх, үүнд дараах үүрэг амлалт багтсан байна уу			
	a.	Бодит байнгын харилцаа, оролцоотой юу?			
	b.	Хүндэтгэлтэй харилцдаг уу?			
	c.	Шинэ төсөл эхлүүлэх эсвэл өргөтгөл хийхээс өмнө сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн чөлөөт, урьдчилсан, мэдлэгтэйгээр өгсөн зөвшөөрлийг авахыг зорьдог уу ?			
	d.	Уурхайн үйл ажиллагаатай холбогдон гарч буй боломжууд нь нутгийн иргэдэд тэгш, хүртээмжтэй байна уу ?			
	e.	Сөрөг нөлөөнд өртсөн нутгийн иргэдэд урт хугацааны тогтвортой үр өгөөж хүртээхийг зорьдог уу ?			
	2.	Сөрөг нөлөөнд шууд өртөж буй нутгийн иргэдтэй дараах чиглэлээр харилцах, оролцоог нь хангах үйл явц тогтсон уу ?			
	a.	Нутгийн иргэдэд чухал ач холбогдол бүхий зүйлсийг, үүнд соёлын хувьд ач холбоо бүхий газар нутаг ³ , тэдний эрх болон ашиг сонирхолд хэрхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болох болон эдгээр сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулж болох талаар ойлголт авахаар эрэлхийлдэг үү ?			
	b.	Орон нутгийн хэл, уламжлал, заншил болон сөрөг нөлөөнд өртөж буй иргэдийн бий болгосон нутгийн иргэдийн засаглал, оролцооны үйл явцын талаар мэдээлэлтэй байна уу ?			
	c.	Иргэдийн өргөн хүрээний дэмжлэг авч, үүнийг удаан хугацаагаар хадгалан үлдээх чиглэлээр бодит, хүндэтгэлтэй харилцааар төлөвлөсөн байна уу ?			

3 ТУУТ (TSM) стандартыг баримтлах замаар Коппер Марк (Copper Mark) байгууллагын шаардлагуудыг хангахаар ажиллаж буй уурхайн хувьд соёлын өвийг хамгаалахтай холбоотой нэмэлт шаардлагыг тус стандартын Хариуцлагатай худалдан авалтын нэмэлт баримт, 24 дүгээр зүйл дээр (Responsible Sourcing Alignment Supplement) заасан ба үүний хүрээнд уурхай нь соёлын өв бүхий газар нутгийг олж тодорхойлох, оролцогч талуудтай хийх зөвлөлдөх арга хэмжээнд суурилсан, соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, багасгах, нөхөн төлөх үйл явцыг бий болгосон байхыг шаарддаг.

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
	d.	Соёл, оюун санаа болон/ эсвэл нутгийн мэдлэгийг орон нутгийн нутгийн иргэд, байгууллагуудаас эрэлхийлж, боломжтой үед өөрийн шийдвэр, арга ажиллагаанд үр дүнтэйгээр тусгаж байна уу?			
	3.	Уурхай нь сөрөг нөлөөлөлд шууд өртсөн нутгийн иргэдтэй хамтран ажиллаж орон нутгийн боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, бизнес, орлого олох боломж, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүд болон бусад чиглэлээр хамтран ажиллах боломжуудыг тодорхойлдог уу?			
	4.	Уурхай нь өөрийн сөрөг нөлөө үзүүлж буй соёлын хувьд ач холбогдол бүхий газар нутгийн талаар (байгаа бол) шууд сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй хамтын хэлцэлд хүрэх зорилтыг дэвшүүлсэн үү?			
	5.	Томилогдсон ажилтнуудын чадамжийг хангах болон/эсвэл дараах чиглэлээр сургалт хийх үйл явцыг боловсруулж (эсвэл хэрэгжүүлж) байна уу:			
	a.	Зөвлөлдөх арга хэмжээний шаардлагууд			
	b.	Сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн түүх, уламжлал болон эрхийн?			
	c.	Соёлын ялгаатай байдлаг мэдлэг, оролцоо?			
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 3 Түвшин АА	1.	Нутгийн иргэдийн зүгээс өмнө бүрдүүлсэн оролцооны протоколыг уурхай батлан хэрэгжүүлж буйгаас бусад тохиолдолд оролцооны үйл явцыг шууд сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй хамтран боловсруулсан (эсвэл боловсруулах буй) байна уу? Үүнд дараан үйл явцыг боловсруулах үйл ажиллагааг багтаасан уу:			
	a.	Уурхай болон шууд нөлөөнд өртөж буй иргэд хэрхэн харилцан зөвшилцөлд хүрэхээр хичээх болохыг тодорхойлох?			
	b.	Хэрэв байгаа бол шийдвэр гаргах уламжлалт үйл явцыг хэрхэн уялдуулан хангахыг тодорхойлох?			

АСУУЛТ		Т	Ү	НА	Тайлбар ба нотолгоо
	с. Зөрчлийг үр дүнтэйгээр шийдэх?				
	2. Шууд нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэдтэй хамтран тодорхойлсон боломжуудын чиглэлээрх харилцан зөвшилцсөн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл явц хэрэгжиж байна уу?				
	3. Нутгийн иргэдийн талаарх боловсрол, мэдлэг болон/эсвэл түүх, уламжлал, эрх, соёлын ялгаатай байдлын мэдлэг, оролцооны сургалтууд нь доорх нөхцөлийг хангасан байна уу:				
	а. Бүх ажилтнуудад зориулагдсан, нээлттэй байх?				
	б. Зөвхөн удирдлага болон томилогдсон ажилтнуудаас бусад ажилтнуудад хүрэх зорилттой байх?				
	4. Боловсрол, мэдлэгийн агуулга нь дараах шаардлагад нийцсэн байна уу:				
	а. Нутгийн иргэдтэй хамтран боловсруулсан болон/эсвэл заадаг байх?				
	б. Нутгийн иргэдийн оролцоотойгоор байнга эргэн хянаж, шинэчилдэг байх?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 3 Түвшин ААА	1. АА түвшин дээр тодорхойлсон харилцаа, оролцооны үйл явцыг хэрэгжүүлж, шууд сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдтэй зөвшилцөлд хүрсэн эсвэл харилцан зөвшөөрсөн үүрэг амлалт авсан байна уу				
	2. Уурхай нь нутгийн иргэдтэй хийсэн гэрээ хэлцэл, зөвшилцлийг даган мөрдөж, хэрэгжүүлж, хэрэгжилтийг хянаж буйгаа илтгэн харуулдаг уу				
	3. Уурхай нь АА түвшинд тодорхойлсон хамтын зорилтууд дээр нутгийн иргэдтэй хамтран ажилладаг, үр дүн эсвэл өгөөж бий болгоход гарч буй ахиц дэвшлийн талаарх нотолгоог гарган өгдөг үү				
	4. Зорилтуудаа хангаж буйг хэмжих хамтын үнэлгээний үйл явц бүрдэж, үүнд дараах үйл явц багтсан байна уу:				

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
a.	Гүйцэтгэлийг нутгийн иргэдтэй хамтран баталгаажуулдаг уу?				
b.	Зорилтууд нь биелэгдээгүй тохиолдолд нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлдэг үү?				
5.	Ажилтнуудынхаа нутгийн иргэдийн түүх, уламжлал болон эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, соёлын ялгаатай байдлын талаарх мэдлэг, мэдрэмжтэй харилцааг бий болгох чиглэлээр дараах ажлуудаас хамгийн багадаа гурван ажлыг хийдэг үү :				
a.	Уурхайн ажилтнуудад нутгийн иргэдийн түүх, уламжлал, эрх болон соёлын ялгаатай байдлын талаарх мэдлэг олгох, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах				
b.	Орон нутагт хийгдэж буй соёлын үйл ажиллагааг уурхайн зүгээс дэмжих				
c.	Уурхай нь өөрийн ажилтнууд орон нутгийн арга хэмжээнд оролцоход хөхиүлэн дэмжих?				
d.	Уурхай нь орон нутаг, бүс нутаг болон/эсвэл улсын хэмжээний нөлөөллийн ажлуудад хувь нэмэр оруулах эсвэл оролцох				
e.	Мэдлэг, мэдээлэл олгох сургалтууд үр дүнтэй байгаа эсэхийг тогтмол үнэлэх				
f.	Мэдлэг, мэдээлэл олгох сургалтуудыг зөвхөн уурхай дээр биш илүү өргөн хүрээнд өргөжүүлэх				
g.	Уламжлалт болон соёлын үйл ажиллагааний протоколыг бизнесийн практиктай уялдуулан нэгтгэх				
Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайг ААА түвшинд хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ		Түвшин:_____			

АСУУЛТ		T	Y	NA	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 4: ОРОН НУТАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ БОЛОН ҮР ӨГӨӨЖИЙН МЕНЕЖМЕНТ					
Үзүүлэлт 4 Түвшин В	1.	Уурхайн үйл ажиллагаанаас улбаатайгаар Сонирхогч талуудын бүлэгт шууд нөлөө үзүүлэх болон бодитоор үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох болон бууруулах, орон нутагт өгөх үр өгөөжийг оновчтой болгохын тулд ахлах удирдлагын зүгээс үүрэг амлалт авсан байна уу ?			
	2.	Энэхүү үүрэг амлалтыг хэрэгжүүлэх үүрэг роль, чиг үүргийг оногдуулсан байна уу?			
	3.	Уурхай нь өөрийнх нь үйл ажиллагаанаас сонирхогч бүлгүүдэд сөргөөр нөлөөлж буй болон эсвэл боломжит нөлөөг тодорхойлсон байна уу?			
Үзүүлэлт 4 Түвшин В	4.	Уурхайн нь тодорхойлсон сөрөг нөлөөллөө бууруулах чиглэлээр зарим хүчин чармайлт гаргаж буйгаа илтгэн харуулж байна уу?			
	5.	Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зарим шийдвэрүүд гарсан байна уу?			
	6.	Уурхай нь сөрөг нөлөөлөл, нөлөөллийн чиг хандлага болон нөлөөллийн менежментийн талаар хааяадаа мониторинг хийдэг үү ?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ..				
Үзүүлэлт 4 Түвшин А	1.	Уурхайн үйл ажиллагаанаас улбаатайгаар Сонирхогч талуудын бүлэгт шууд нөлөөлөл үзүүлэх болон бодитоор үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, эрэмбэлэх, сэргийлэх болон бууруулахад Сонирхогч талуудын бүлгийн оролцоог хангах үйл явц тогтсон уу?			
	2.	Боломжит болон бодит нөлөөллийг эрэмбэлэх үйл явц нь дараах нөлөөллийг харгалздаг уу?			
	a.	Уурхай үйл ажиллагаа явуулж буйн улмаас гарч болох нийгмийн сөрөг нөлөөлөл			
	b.	Нутгийн иргэдэд шууд нөлөөлөх байгаль орчны сөрөг нөлөөлөл, үүнд хаягдлын менежменттэй холбоотой нөлөөлөл (хамаатай бол)			
	c.	Орон нутгийн аюулгүй байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл			

АСУУЛТ		T	Y	NA	Тайлбар ба нотолгоо
3.	Харилцах, оролцоог хангах үйл явц нь хязгаарлагдмал төлөөлөл бүхий болон тодорхойлон гаргасан боломжит болон бодит сөрөг нөлөөлөлд хамгийн ихээр өртөж буй Сонирхогч бүлгүүдийн төлөөллийг оролцуулах арга хэмжээг багтаасан байх.				
4.	Нөлөөллийг эрэмбэлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамаарах Сонирхогч талуудтай хамтран хийсэн байна уу?				
a.	Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хамаарах зорилтууд, хүрэх түвшнийг тодорхойлсон байх, эдгээрийг хянаж, эргэн шалгаж, сөрөг нөлөөнд өртөж буй Сонирхогч талуудын бүлгийн хамтаар уян хатан удирдаж байх				
b.	Үйл ажиллагааны төлөвлөгөө нь нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь хэрхэн Сонирхогч бүлгийн хүртэх өгөөжийг оновчтой болгож болохыг харгалзан тусгасан байх.				
5.	Сонирхогч бүлгийн хүртэх үр өгөөжийг оновчтой болгох боломжийг тодорхойлох, эрэмбэлэхэд хамаарах бүлгийг татан оролцуулах үйл явц тогтсон байх. Үүнд орон нутгийн худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт болон бусад санаачлагууд багтсан байна уу?				
6.	Орон нутгийн үр өгөөжийг оновчтой болгохоор эрэмбэлсэн боломжуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамаарах Сонирхогч бүлгүүдийн оролцоотойгоор боловсруулан гаргаж, хэрэгжүүлж байна уу?				
a.	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хамаарах зорилтууд болон хүрэх түвшнийг тогтоож, эдгээрийг эргэн хянаж, үнэлж, сөрөг нөлөөнд өртөж буй бүлэгтэй хамтран уян хатан удирдаж байна уу?				
7.	Уурхайн зүгээс орон нутгийн хөгжлийн санаачилгуудад оруулж буй хувь нэмэр дээр хамаарах Сонирхогч талуудын бүлэгтэй харилцдаг, оролцоог хангах үйл явц тогтсон байна уу?				
8.	Орон нутгийн хөгжлийн санаачилгуудад оруулж буй хувь нэмрийн талаар олон нийтэд мэдээлдэг үү?				
9.	Эрэмбэлсэн тэргүүлэх ач холбогдол бүхий сөрөг нөлөөллийн талаарх суурь өгөгдөл цуглуулдаг уу?				
10.	Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт хийх хэмжих үзүүлэлт гаргасан байна уу?				

		АСУУЛТ	Т	Ү	НА	Тайлбар ба нотолгоо
	11.	Сөрөг нөлөөнд өртөж буй сонирхогч талуудын бүлэгтэй хамтран байнгын, урьдчилан тогтоосон давтамж, үндэслэлтэйгээр төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг хянадаг уу?				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.					
Үзүүлэлт 4 Түвшин АА	1.	Эрэмбэлэн гаргасан сөрөг нөлөөллөөс сэргийлэх эсвэл бууруулахын тулд хамаарах Сонирхогч талуудын бүлэгтэй хамтарсан шийдвэр гаргадаг үйл явц тогтсон байна уу ?				
	2.	Сонирхогч талуудын бүлгийн өгөөжийг оновчтой болгох боломжуудыг тодорхойлох, эрэмбэлэх үйл явц нь дараах боломжуудыг харгалзсан уу:				
	a.	Орон нутагт аль болох олон хүнд үр өгөөжтэй байх.				
	b.	Уурхайн үйл ажиллагаа дууссанаас хойш бие даан хөгжих боломжтой байх				
	3.	Хамаарах Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран шийдвэр гаргах, талуудын хүртэх үр өгөөжийг оновчтой болгох үйл явц тогтсон байх.				
	4.	Уурхайн зүгээс орон нутгийн хөгжлийн чиглэлээр оруулах хувь нэмрийг Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран гаргадаг байх.				
	5.	Уурхай нь боломжтой бол Сонирхогч талын бүлэгтэй хамтран өөрийн тодорхойлсон, эрэмбэлсэн сөрөг нөлөөллийн чиг хандлагыг байнга хэмжиж, дүн шинжилгээ хийдэг үү? Уурхай нь мөн орон нутгийн үр өгөөжийг оновчтой болгох боломжуудыг байнга хэмжиж, дүн шинжилгээ хийж, гарч буй хийдлийг хэрхэн шийдэх талаар Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран ажиллаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт арга хэмжээ авдаг уу ?				
Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.						
Үзүүлэлт 4 Түвшин ААА	1.	Уурхай нь Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран эдгээр бүлгүүд уурхайн үйл ажиллагаа дууссаны дараа гарах сөрөг нөлөөллийг бууруулах, үр өгөөжийг оновчтой болгон ажиллах чадвартай болоход нь дэмжин ажилладаг уу ?				

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
a.	Сөрөг нөлөөлийг бууруулах болон үр өгөөжийг оновчтой болгоход шаардлагатай боломжит түншлэл болон төрийн байгууллагын үүрэг ролийг тодорхойлсон уу ?				
b.	Урт хугацааны сөрөг нөлөөллийг бууруулах болон/эсвэл уурхайн үйл ажиллагаа зогссоны дараа орон нутагт очих үр өгөөжийг оновчтой болгох боломжуудыг тодорхойлон гаргасан бол эдгээрийг урт хугацааны хөрөнгө оруулалтын шийдвэр болон/эсвэл хаалтын төлөвлөгөөнд уялдуулан нэгтгэх замаар урт хугацааны тогтвортой байдлыг хангадаг уу?				
2.	Сонирхогч талуудын бүлэг нь хамтын алсын хараа эсвэл хөгжлийн төлөвлөгөө (эсвэл ижил төстэй баримт бичиг) байхгүй, Сонирхогч бүлэг нь өөрөө сонирхож байвал уурхай нь ийм төлөвлөлт эхлүүлэхэд нь эдгээр бүлэгт дэмжлэг үзүүлдэг үү ?				
3.	Уурхай нь сөрөг нөлөөлөлд өртсөн Сонирхогч бүлэгтэй дараах ажлуудын үр дүнтэй байдлыг хянах чиглэлээр хамтран ажилладаг уу ?				
a.	Орон нутагт үр өгөөжтэй байх үйл ажиллагааг эрэмбэлэн , оновчтой байлгадаг уу ?				
b.	Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээрх авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд?				
Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайг ААА түвшинд үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 4 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ		Түвшин:_____			

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 5: СОНИРХОГЧ БҮЛГҮҮДТЭЙ ХАРИЛЦАХ МЕХАНИЗМ					
Үзүүлэлт 5 Түвшин В	1.	Харилцах механизм зарим хэлбэрээр тогтсон уу?			
	2.	Албан ёсны харилцах механизм үүсгэхээр төлөвлөсөн эсвэл бүрдүүлэх үйл явц хийгдэж байна уу?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 5 Түвшин А	1.	Хариу өгөх механизм нь Сонирхогч талуудын бүлгүүдээс гомдол, санал, хүсэлт хүлээн авах, эдгээрийг удирдах, хариу өгөх тодорхой үйл явцтайгаар бүрдэн бий болсон байж, үүнд дараах багтсан уу:			
	a.	Мэдээлсэн тохиолдол, асуудлууд, эргэн өгсөн хариуг бүртгэх?			
	b.	Аль гомдолд арга хэмжээ авах шаардлагатайг үнэлэн, тодорхойлох?			
	c.	Аливаа санал хүсэлт, гомдолд цаг тухайд нь хариу өгдөг эсэх			
	d.	Хариу өгөх механизм нь хүртээмжтэй эсэх?			
	2.	Уурхай нь Сонирхогч талуудын бүлгээс гаргасан асуудлууд, эдгээрт хариу өгөх төлөв байдлыг бүртгэдэг эсэх			
	3.	Сонирхогч талуудын бүлэгт уурхайн харилцах механизмыг хэрхэн ашиглах талаар урьдчилан, тодорхой мэдээлдэг үү?			
Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.					
Үзүүлэлт 5 Түвшин АА	1.	Харилцах механизмыг шууд сөрөг нөлөөлөлд өртөж буй Сонирхогч талуудын бүлэгтэй хамтран боловсруулсан уу?			
	2.	Харилцах механизмыг багадаа жил тутамд эргэн хянаж, сайжруулах боломжуудыг тодорхойлдог эсэх?			
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				

АСУУЛТ		Т	Ү	NA	Тайлбар ба нотолгоо
Үзүүлэлт 5 AAA	1.	Хариу өгөх механизм хангалттай хэмжээнд ажиллаагүй тохиолдолд тухайн гомдлыг дараагийн шатанд шилжүүлэн шийддэг механизм бүрдэн тогтсон уу?			
	2.	Хариу өгөх механизм нь арга хэмжээ авсны дараа хэрэглэгчдэд эргэн мэдээлдэг үйл явцтай байна уу?			
	3.	Хариу өгөх механизмын үр дүнтэй байдлыг эргэн хянаж, тогтмол сайжруулдаг эсэх?			
	Хэрэв AAA түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайг AAA түвшинд хэмээн үнэлнэ. Хэрэв AAA түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг AA түвшинд хэмээн үнэлнэ.				
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 5 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ			Түвшин:_____		



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**

Нутгийн иргэд болон орон нутгийн харилцааны протокол

ТУУТ санаачилгын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:

www.TSMInitiative.com

эсвэл

Канадын Уул Уурхайн Ассоциаци

www.mining.ca/tsm

Энэхүү нийтлэлийг боловсрол болон ашгийн бус бусад зорилгоор Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг зөвшөөрнө. Гэхдээ эх сурвалжийг бүрэн дурдсан байх шаардлагатай.

Энэхүү нийтлэлийг борлуулах болон бусад арилжааны зориулалтаар хуулбарлахыг Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хориглоно.

©2021 Канадын Уул Уурхайн Ассоциаци. Towards Sustainable Mining®, TSM®, зэрэг барааны тэмдгүүд нь Канад эсвэл бусад улс орнуудад Канадын Уул Уурхайн Ассоциацийн бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй барааны тэмдэг болно.



**МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ**



www.miningmongolia.mn



Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци



Mongolian National Mining Association



@miningmongolia



@mongolian_mining_association



Info@miningmongolia.mn



+976 7011 0163